



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

### ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## УУЛ УУРХАЙН САЛБАРТ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ АЖ АХУЙН НЭГЖ БАЙГУУЛЛАГУУД УЛСЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН 29.8 ХУВИЙГ БҮРДҮҮЛЖ БАЙНА

**АУДИТЫН СЭДЭВ: УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН  
БҮРДҮҮЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭЛ**

**АУДИТЫН КОД: АНУЗГ-2023/22-ШТА-ГА**



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал,  
тэргүүлэх аудитор Я.Самбууням

Утас: 263755, цахим хаяг: [sambuunyamya@audit.gov.mn](mailto:sambuunyamya@audit.gov.mn)

Аудитын удирдлагын менежер Б.Болормаа

Утас: 261805, цахим хаяг: [bolormaab@audit.ygov.mn](mailto:bolormaab@audit.ygov.mn)

Ахлах аудитор Ү.Төгсжаргал

Утас: 261456, цахим хаяг: [tugsjargalu@audit.gov.mn](mailto:tugsjargalu@audit.gov.mn)

Ахлах аудитор С.Одонцэцэг

Утас: 261456, цахим хаяг: [odontsetsegs@audit.gov.mn](mailto:odontsetsegs@audit.gov.mn)

Ахлах аудитор Б.Эрдэнэзул

Утас: 261675, цахим хаяг: [erdenezulb@audit.gov.mn](mailto:erdenezulb@audit.gov.mn)

Ахлах аудитор Л.Нямтөмөр

Утас: 261675, цахим хаяг: [nyamtumurl@audit.gov.mn](mailto:nyamtumurl@audit.gov.mn)

Аудитор А.Мөнхбадрал

Утас: 261456, цахим хаяг: [munkhbadrala@audit.gov.mn](mailto:munkhbadrala@audit.gov.mn)

Аудитор М.Одгэрэл

Утас: 262451, цахим хаяг: [odgerelm@audit.gov.mn](mailto:odgerelm@audit.gov.mn)

Улаанбаатар хот 2023 он



МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН  
ТУШААЛ

2023 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/86

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 29 дүгээр зүйлийн 29.1.9 дэх заалт, 29.3 дахь хэсэг, 33 дугаар зүйлийн 33.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг нэгдүгээр, аудитаар өгсөн албан шаардлагыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталгаажуулсугай.

2. Аудитын тайланг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Татварын Ерөнхий газар газар, Ашигт малтмал, газрын тосны газарт тус тус хүргүүлэхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т үүрэг болгосугай.

3. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн сайд (Б.Жавхлан), Уул уурхай хүнд үйлдвэрийн сайд (Ж.Ганбаатар), Татварын Ерөнхий газрын дарга (Б.Заяабал), Ашигт малтмал, газрын тосны газрын дарга (Л.Баярмандал) нарт зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцон ажиллахыг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т даалгасугай.

5. Аудитын тайланг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодоор хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хангаж, танилцуулга хийхийг Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ц.Наранчимэг)-д даалгасугай.

6. Аудитын тайланг баталгаажуулснаас хойш 14 хоногт багтаан аудитын ажлын болон нотлох баримтыг архивын нэгж болгон Үндэсний аудитын газрын архивд хүлээлгэн өгөхийг Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газар (Я.Самбууням)-т үүрэг болгосугай.

Д.ЗАНДАНБАТ

## АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ.....	3
АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ .....	4
ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ .....	6
<b>БҮЛЭГ НЭГ. ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ОРЛОГЫГ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТООЦООЛОЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА. ....</b>	<b>7</b>
Уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын баримт, хууль тогтоомжийн өөрчлөлт хийх ажил удаашралтай, зарим төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжээгүй байна.....	7
Уул уурхайн салбарын төсвийн орлогын төлөвлөгөөг улсын эдийн засгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэж боловсруулаагүй байна. ....	9
<b>БҮЛЭГ ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХООРОНДОО МЭДЭЭЛЛИЙГ ТОГТМОЛ СОЛИЛЦСОНООР АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ БҮРЭН НОГДУУЛЖ, ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА.....</b>	<b>11</b>
Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний талаар холбогдох хууль, журамд заасны дагуу төрийн байгууллагууд тухай бүр харилцан мэдээлэл солилцоогүй байна. ....	11
Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг хэдий ч татварын хуримтлагдсан өртэй байна. ....	14
Тогтворжуулалтын сангаас төсвийн алдагдлыг санхүүжүүлэхдээ холбогдох хуулийг мөрдөж ажиллаагүй байна.....	18
Ирээдүйн өв сангийн батлагдсан төсвийг хэтрүүлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулжээ. ....	19
Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал .....	20
Үндэсний аудитын газрын тайлбар .....	22
ДҮГНЭЛТ .....	23
ЗӨВЛӨМЖ:.....	24
Хавсралт 1.....	25
Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт.....	25
(2022 оны жилийн эцсийн байдлаар).....	25
Хавсралт 2.....	27
Тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнийг Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгүүлээгүй..	27
Хавсралт 3.....	27
Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгэгдсэн боловч Татварын Ерөнхий газарт бүртгээгүй, татвар төлөгдөөгүй ААН-ийн жагсаалт .....	27
Хавсралт 4.....	28
Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэсэн /30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт орсон тодорхойлолттой боловч Татварын ерөнхий газарт бүртгэгдээгүй, татвар төлөгдөөгүй ААН-ийн жагсаалт	
Хавсралт 5.....	28
Улсын бүртгэлийн ерөнхий газарт тодорхойлолтгүй /30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт орсон/ бүртгэгдсэн .....	28

**ТОВЧИЛСОН ҮГС ИЙН ЖАГСААЛТ**

<b>Товчлол</b>	<b>Тайлал</b>
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМГТГ	Ашигт малтмал, газрын тосны газар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АМТХ	Ашигт малтмалын тухай хууль
ААН	Аж ахуйн нэгж
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АТБӨЯХАТ	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслэлийн албан татвар
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БХГ	Бүтээгдэхүүн хуваах гэрээ
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
СЯ	Сангийн яам
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
МХЕГ	Мэргэжлийн хяналтын ерөнхий газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
УИХ	Улсын Их Хурал
УБЕГ	Улсын бүртгэлийн ерөнхий газар
УУХҮЯ	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХЭУБТХ	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани

## АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО, ХАМРАХ ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

### Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2022 оны 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хэрэгжүүллээ.

### Аудитын зорилго

Уул уурхайн салбарын төсвийн орлогын бүрдүүлэлт, гүйцэтгэл сэдэвт аудитаар төсвийн орлогын бүрэлдэхүүн хэсэг болох уул уурхайн салбарын орлогыг хэрхэн бүрдүүлж буй нөхцөлийг тодруулж, дүн шинжилгээ хийн дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын Хороо болон СЯ, ТЕГ-ын холбогдох албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилго чиглэсэн.

Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэсэн. Үүнд:

- ✓ Уул уурхайн салбарын 2019-2022 оны төсвийн орлогын төлөвлөлт оновчтой эсэх;
- ✓ Уул уурхайн салбарын 2019-2022 оны төсвийн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэх.

### Аудитын хамарсан хүрээ

Аудитад СЯ, УУХҮЯ, ТЕГ, АМГТГ, УБЕГ, ГЕГ-ын 2019-2022 оны уул уурхайн салбарын үйл ажиллагаатай холбоотой татварын орлогын төлөвлөгөө, тайлан, бусад холбогдох мэдээлэл зэргийг хамрууллаа.

### Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100, 300, 3000-3100 стандартад нийцүүлэн баталсан дараах стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”,
- MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”,
- MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит”.

Аудитад Сангийн яамнаас 2019-2022 онд татварын орлогын төлөвлөлтийг боловсруулахад хийсэн макро түвшний төсөөлөл, АМГТГ-ын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, түүний шилжилт хөдөлгөөн, аж ахуйн нэгж байгууллагын уулын ажлын төлөвлөгөө, тайлан, ТЕГ-т бүртгэлтэй ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй болон тусгай зөвшөөрөлгүй “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр” төлсөн аж ахуйн нэгж байгууллагын ногдол, төлөлтийг татварын нэр төрлөөр, УБЕГ, ГЕГ-аас гаргасан мэдээлэл зэрэг нотлох баримтыг шалгуур үзүүлэлттэй нягтлан шалгах, харьцуулсан дүн шинжилгээ болон тулган баталгаажуулалт хийх зэрэг арга зүйг ашиглалаа.

Мөн уул уурхайн салбараас төсвийн орлогын бүрдүүлэлттэй холбоотой хууль, эрх зүйн акт болон олон улсын байгууллагын тайланг судлан, уул уурхайн салбар хариуцсан төрийн болон төрийн бус байгууллагын албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага хийх, аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу горим сорил хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, тэдгээрийн дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

### Аудитын шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төсвийн тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль;
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;

- Ашигт малтмалын тухай хууль;
- Газрын төлбөрийн тухай хууль;
- Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль;
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль;
- Гүйцэтгэлийн аудитын удирдамж /АДБОУС 3000-3100/;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 342 дугаар тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоол;
- Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 193 дугаар тогтоол;
- Дээрх хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан холбогдох байгууллагын шийдвэрүүд зэрэг болно.


## ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтэд уул уурхайн салбар голлох нөлөө үзүүлдэг бөгөөд 2019-2022 оны байдлаар улсын төсвийн нийт орлогын 29.8 хувийг ашигт малтмал, уул уурхайн салбарын орлого эзэлж байна<sup>1</sup>.

Монгол Улсын нэгдсэн төсвийн орлого 2022 оны жилийн эцсийн байдлаар 18,521.6 тэрбум төгрөгт хүрснээс уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний орлого 2022 онд 5,516.0 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд 2019 онтой харьцуулахад 2,146.0 тэрбум төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна.

Энэ нь дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлаас шалтгаалсан хилийн хорио цуцлагдаж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ болон эрдэс баялгийн бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн үнэ харьцангуй өсөн тогтвортой байгаа, ААНБ-ын үйл ажиллагаа сэргэж өссөнтэй холбоотой байна. (Хавсралт 1)

Хүснэгт 1. Монгол Улсын нийт орлого ба тусламжийн дүнд уул уурхайн салбарын орлогын эзлэх дүн, хувь хэмжээ, тэрбум төгрөг



Эх сурвалж: УАГ

Эрдэс баялгийн дараах гол нэр төрлийн бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 1. Уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтын хэмжээ

Бүтээгдэхүүний нэр төрөл	Уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны биет хэмжээ							
	2019 он		2020 он		2021 он		2022 он	
	төлөв	Гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц	төлөв	гүйц
Зэсийн баяжмал /мян.тн/	1,400.0	1,403.6	1,225.0	1,395.1	1,186.0	1,282.5	1,200.0	1,500.0
Нүүрс/мян.тн/	42,000.0	36,748.8	42,000.0	28,700.0	28,700.0	16,200.0	18,000.0	31,800.0
Алт /тн/	21.0	13.2	19.0	30.5	16.0	17.2	20.0	17.7
Цайр/мян.тн/	78.2	134.8	141.8	134.1	119.2	112.6	121.2	141.2
Төмрийн хүдэр /мян.тн/	7,550.0	8,448.8	8,280.0	8,202.3	8,399.6	7,106.2	5,100.0	4,700.0
Жонш /мян.тн/	360.0	699.4	799.4	678.9	714.0	644.7	193.5	387.7
Боловсруулаагүй нефьт /мян.бар/	8,100.0	6,500.0	6,235.0	4,070.5	5,873.8	4,348.9	3,400.0	2,600.0

Эх сурвалж: УУХҮЯ

Уул уурхай, газрын тосны бүтээгдэхүүний 2022 оны орлогын 52.8 хувийг АМНАТ, 20.1 хувийг ААНОАТ, 27.1 хувийг бусад татвар, хураамж эзэлсэн бөгөөд АМНАТ-ийн 2,912.5 тэрбум төгрөгийн орлогоос тогтворжуулалтын санд 1,156.4 тэрбум, Ирээдүй өв санд 1,140.5 тэрбум төгрөг, улсын төсөвт 615.5 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

<sup>1</sup> Төсвийн тухай хуулийн 23.1-д "Төсвийн орлого нь татварын орлого, татварын бус орлогоос бүрдэнэ".



## **БҮЛЭГ НЭГ. ЭРДЭС БАЯЛГИЙН САЛБАРЫН ОРЛОГЫГ МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, ТООЦООЛОЛД ҮНДЭСЛЭН ТӨЛӨВЛӨХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.**

**Уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бодлогын баримт бичиг болон хууль тогтоомжид өөрчлөлт хийх ажил удаашралтай, зарим төлөвлөсөн ажлууд бүрэн хэрэгжээгүй байна.**

1.1. Уул уурхайн бүтээгдэхүүний үнэлгээг олон улсын зах зээлийн жишиг үнээр үнэлэн, түүнээс хүртэх үр ашиг, нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөг нэмэгдүүлэх, уул уурхайн бүтээгдэхүүний нийлүүлэгч, худалдан авагчийг холбох, зах зээлийн бодитой ханш тогтоох, хөрөнгө оруулагчдыг найдвартай мэдээллээр хангах, татвар хураамжийг үндэслэлтэй тооцох зэрэг нээлттэй ил тод хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхэд чиглэсэн дараах хууль тогтоомж болон Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацаанд хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүд батлагдсан байна. Үүнд:

- "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого (2020.05.13);
- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл (2020.08.28);
- Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр (2020.08.28);
- Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө (2021.07.01);
- Шинэ сэргэлтийн бодлого (2021.12.30);
- Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль (2022.12.23).

1.2. УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 4.6-д "Эдийн засгийн төрөлжилт, инновац, шинэ технологи, хүний хөгжил, ногоон хөгжлийн зорилтуудыг дэмжих чадавхтай олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн баялгийн санг бий болгоно" гэсэн зорилтыг хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

*I үе шат (2021-2030 он) - Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийх үе буюу хөрөнгийн удирдлагыг нэгдсэн бодлогоор хэрэгжүүлэх, санхүүгийн үр ашигтай төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлэн дэмжих, хөрөнгийн хуримтлалыг бий болгох тогтолцоог бүрдүүлж, хөгжүүлэх;*

*II үе шат (2031-2040 он) - Мега, нийгэм-эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр болон гадаадын санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах замаар эдийн засгийг дэмжих, баялгийн сангийн хөрөнгийг арвижуулж, нийгмийн ач холбогдол бүхий төсөл, хөтөлбөрүүдийг дэмжиж, улмаар иргэдийн амьжиргааг дээшлүүлэх чадавхыг бүрдүүлэхээр төлөвлөжээ.*

1.3. Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 4.6-д "Баялгийн сан байгуулж, санхүүгийн үр ашигтай төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулалт хийнэ" гэсэн эдийн засгийн бодлогыг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.4. Дээрх зорилтыг хангах зорилгоор хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж буй нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, ашиглалтад оруулах ажлын хэрэгжилт дараах байдалтай байна. Үүнд:

- Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийх ажил нь Ковид-19 цар тахал, БНХАУ-ын Гашуунсухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурснаас Эрдэнэс Монгол ХХК-д санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул хойшлогдсон;
- Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ыг түшиглэн "Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил удааширснаар төлөвлөсөн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй;
- Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг



гүйцэтгэхэд шаардлагатай дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлууд бүрэн хэрэгжээгүй;

- Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажил цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан гүйцэтгээчийг сонгон шалгаруулах ажил удааширснаас 70 хувийн гүйцэтгэлтэй;
- “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажил нь барилга байгууламжийн суурийн ажил удааширснаас 30 хувийн гүйцэтгэлтэй.

1.5. Монгол Улсын Үндсэн хуульд 2019 онд орсон нэмэлт өөрчлөлтийн 6.2 дахь хэсэгт “Байгалийн баялгийг ашиглах төрийн бодлого нь урт хугацааны хөгжлийн бодлогод тулгуурлаж, одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг нь баталгаажуулах, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг Үндэсний баялгийн санд төвлөрүүлж тэгш, шударга хүртээхэд чиглэнэ” гэж заасан байна.

1.6. УИХ-ын 2020 оны “Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” 02 дугаар тогтоолоор Үндэсний баялгийн сан нь хөгжлийн болон хуримтлалын сан байхаар шийдвэрлэжээ.

1.7. Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх зорилгоор Үндэсний баялгийн сангийн тухай, Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан байна.

1.8. Үүний дагуу Засгийн газраас уул уурхайн бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд борлуулах, түүнээс хүртэх үр ашгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор дараах арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд;

- Байгалийн баялгийг ашиглах шийдвэр, журмыг боловсронгуй болгох чиглэлээр уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд хяналт тавих, эрх зүйн үндсийг боловсронгуй болгох зорилгоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2022 оны 12 дугаар сарын 23-ны өдөр батлуулсан;
- Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсгийг УУХҮС-ын 2023 оны А/55 дугаар тушаалаар байгуулж, 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Ашигт малтмалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалыг батлуулсан;
- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төслийг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2022 оны 192 дугаар захирамжаар байгуулж, хуулийн төсөлтэй холбоотой суурь судалгаа, сангийн менежментийн удирдлагын тогтолцоо, гадаад улс орнуудын туршлагыг судлах ажил хийгдсэн боловч Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг УИХ-д өргөн мэдүүлэх ажил удааширсан.

1.9. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2-т “Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд төлөвлөсөн дараах төсөл, арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүнд;

3.2.1.3 Цагаан суваргын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах;

3.2.1.5 Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгаа хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх;

3.2.1.5.1 Асгатын мөнгөний ордын туршилт судалгааны хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.1.5.1 Асгатын мөнгөний ордын зөвлөх үйлчилгээний хөрөнгө оруулалтын арга хэмжээг хэрэгжүүлэх;

3.2.7.2 Орхон аймагт Эрдэнэтийн төмөрлөгийн үйлдвэрийг ашиглалтад оруулах;

3.2.7.3 Дорноговь аймагт хар төмөрлөгийн цогцолбор үйлдвэр байгуулах зэрэг ажлууд байна.

1.10. Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2-т заасан зорилт нь шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийн асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй, Ковид-19 цар тахлын улмаас хөл хорио, хилийн хязгаарлалт тогтоосноос гүйцэтгэгч нарын түүхий эд материал саатаж бүтээн байгуулалтын ажил хийгдээгүй зэрэг нөлөөлж хэрэгжээгүй байна.

1.11. Монгол Улсын урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтууд бүрэн хэрэгжээгүйгээс баялгийн санд төвлөрөх орлого буурах, нийгэм эдийн засагт сөрөг нөлөө үзүүлж байна.

**Уул уурхайн салбарын төсвийн орлогын төлөвлөгөөг улсын эдийн засгийн төлөв байдалд дүн шинжилгээ хийж, холбогдох байгууллагын мэдээлэлд үндэслэж боловсруулаагүй байна.**

1.12. Сангийн яамнаас<sup>2</sup> уул уурхайн салбарын төсвийн орлогын хэмжээг тооцоохдоо голлох ашигт малтмалын бүтээгдэхүүний олборлолт, экспортын хэмжээ болон макро эдийн засгийн төсөөлөл зэргийг үндэслэдэг байна.

1.13. Сангийн яамнаас дараах хууль тогтоомжийг үндэслэн уул уурхайн салбарын төсвийн орлогын төлөвлөгөөг боловсруулдаг байна. Үүнд:

- АМНАТ-ийг Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан хувь хэмжээ, Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам, аргачлалын дагуу макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдэд үндэслэсэн;
- ААНОАТ-ыг Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан хувь, хэмжээнд үндэслэсэн;
- Гаалийн албан татвар, хураамж, НӨАТ болон бусад орлогын төсөөллийг өмнөх жилийн гүйцэтгэлийг харгалзан тус тус тооцдог байна.

1.14. Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн орлогын дүнгийн 25.6-29.6 хувийг уул уурхайн салбарын орлого эзлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 2. Уул уурхайн салбарын орлогын төлөвлөгөөний эзлэх дүн, хувь хэмжээ, тэрбум төгрөг

Он	Нийт орлого ба тусламжийн дүн	Уул уурхайн салбарын орлогын төлөвлөгөө	Уул уурхайн салбарын орлогын эзлэх хувь
2019	11,272.5	3,335.6	29.6
2020	10,883.0	2,807.7	25.8
2021	13,908.1	3,728.8	26.8
2022	16,743.3	4,281.7	25.6

Эх сурвалж: ЯАГ

1.15. Уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны салбарын орлогын төлөвлөгөөг гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд 1.0-15.9 хувиар давсан үзүүлэлттэй байгаа бөгөөд 2022 онд төсвийн орлого хамгийн өндөр буюу 29.0 хувиар давж биелсэн байна.

1.16. Энэ нь тайлант хугацааны төсвийг батлахдаа Ковид-19 цар тахлын нөхцөл байдал, хилийн хоригоос шалтгаалж нүүрс, зэсийн баяжмал зэрэг бүтээгдэхүүний экспортын хэмжээг бууруулан төлөвлөсөн боловч 2022 оны эцэст дээрх нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс нүүрс, зэсийн баяжмал, цайрын орлогын хэмжээ нэмэгдсэн байна.

Хүснэгт 3. Уул уурхайн бүтээгдэхүүн, газрын тосны салбарын 2019-2022 оны нийт орлого, тэрбум төгрөг

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	2018 гүйцэтгэл	2019 он		2020 он		2021 он		2022 он	
			төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл	төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Зэсийн баяжмал	999.0	1,304.4	1,333.3	1,122.8	1,266.3	1,669.3	2,448.2	1,966.7	2,425.6
2	Нүүрс	998.0	1,310.8	1,282.2	1,056.3	877.7	1,287.8	980.9	1,346.5	2,260.7
3	Алт	80.0	82.5	116.8	205.5	174.0	183.8	227.1	247.4	258.2
4	Цайр	78.0	56.2	67.6	59.5	76.5	74.2	93.0	77.9	182.4
5	Төмрийн хүдэр	31.5	67.2	47.5	90.8	105.2	97.8	189.2	145.7	56.5
6	Жонш	18.2	23.1	39.3	28.2	49.4	71.2	110.8	153.7	33.7
7	Боловсруулаагүй нефьт	222.5	335.6	231.6	110.0	102.7	213.2	198.1	215.4	160.9
8	Бусад	188.9	155.9	251.8	134.5	150.3	131.5	76.9	128.4	138.1
	<b>Дүн</b>	<b>2,616.1</b>	<b>3,335.7</b>	<b>3,370.1</b>	<b>2,807.7</b>	<b>2,802.1</b>	<b>3,728.8</b>	<b>4,324.2</b>	<b>4,281.8</b>	<b>5,516.1</b>

Эх сурвалж: \*Монгол Улсын 2019-2022 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт

1.17. Татварын ерөнхий хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1<sup>3</sup>-д заасны дагуу татвар ногдуулалт, ААНБ-ын төлбөл зохих татварыг үнэн зөв тооцох, татварын нөөц боломжийг

<sup>2</sup>Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2.төсвийн төвлөрүүлэн захирагч, төсвийн төвлөрүүлэн захирагчид харьяалагддаггүй төсвийн шууд захирагч жил бүрийн 8 дугаар сарын 01-ний дотор жилийн төсвийн төслөө харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх; 27.1 Төсвийн төслийг боловсруулахад Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шаардлагаас гадна дараах шаардлага тавигдана: 27.1.2.макро эдийн засгийн төлөв байдал, дүн шинжилгээ, тооцоонд үндэслэсэн байх;

31.4.Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төсөлд дараах тооцоог хавсаргана: 31.4.1.төсөвт төвлөрүүлэх орлогын тооцоо.

<sup>3</sup>Татварын алба татвар төлөгчийн талаар хөндлөнгийн мэдээлэл цуглуулж, хөндлөнгийн мэдээллийн санг бүрдүүлж, мэдээллийг татварын хяналт шалгалт, татвар ногдуулалт, хураалт болон татвар төлөгчийн эрсдэл, бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглах бөгөөд энэ хуулийн 34.3, 34.4, 34.5, 34.6, 34.7, 34.8, 34.9, 34.10, 34.11, 34

нэмэгдүүлэх, харилцан мэдээлэл солилцох зорилгоор Сангийн сайд, Уул уурхайн сайдын 2013 оны 194/173 дугаартай хамтарсан тушаалаар “Татварын ерөнхий газар, Ашигт малтмалын газар хооронд мэдээлэл солилцох журам”, “Харилцан солилцох мэдээллийн жагсаалт”-ыг баталсан байна.

1.18. АМГТГ, ГЕГ, ТЕГ-аас ирүүлсэн гол нэр төрлийн ашигт малтмалын экспортын мэдээг харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт 4. Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын мэдээ, мянган тонн

Ашигт малтмалын төрөл	2019 он			2020 он			2021 он			2022 он		
	Экспортлолсон бүтээгдэхүүний тоо хэмжээ			Экспортлолсон бүтээгдэхүүний тоо хэмжээ, мян. тонн			Экспортлолсон бүтээгдэхүүний тоо хэмжээ, мян. тонн			Экспортлолсон бүтээгдэхүүний тоо хэмжээ, мян. тонн		
	АМГТГ	ГЕГ	ТЕГ	АМГТГ	ГЕГ	ТЕГ	АМГТГ	ГЕГ	ТЕГ	АМГТГ	ГЕГ	ТЕГ
Төмрийн хүдэр, баяжмал	6,637.6	8,448.8	6,991.9	8,386.8	8,205.7	8,643.3	2,176.8	7,105.9	6,828.7	958.8	4,732.2	3,122.5
Жоншны хүдэр, баяжмал	157.1	700.1	325.7	226.4	678.9	158.7	96.6	642.6	139.9	0.0	387.7	166.2
Цайрын баяжмал	124.9	134.8	134.4	125.0	134.1	133.6	105.1	112.6	112.6	0.0	141.2	153.8
Нүүрс /хүрэн/	92.4	137.3	36,536.3	64.3	90.0	29,946.7	349.0	429.6	15,836.8	10.1	127.9	29,012.0
Нүүрс /чулуун/	31,207.3	36,466.8		30,509.5	28,586.8		15,906.5	15,687.1		5,379.5	31,693.7	

Эх сурвалж: ГЕГ, ТЕГ, АМГТГ

1.19. Төрийн захиргааны байгууллагуудын мэдээллийн санд байгаа эрдэс баялгийн бүтээгдэхүүний тоо хэмжээ нь зөрүүтэй байгаа нь АМГТГ, ГЕГ, ТЕГ зэрэг байгууллагуудын чиг үүрэг, мэдээллийн эх үүсвэр, хэрэглээ, оролцогч талуудаас ирүүлдэг мэдээ тайлангийн хугацаа, зорилго тус бүр өөр байдагтай холбоотой байна. Үүнд:

- ГЕГ-ын хувьд экспортлогч ААНБ тухайн эрдэс баялгийн бүтээгдэхүүнийг экспортод гаргахаар гаалийн бүрдүүлэлт хийж, гаалийн төв лабораторийн дүгнэлт гаргуулан улсын хил нэвтрэх ачилт хийгдсэн<sup>4</sup> нийт тоо хэмжээ /ямар нэг механик чийгшил хасаагүй дүнгээр/-г гаалийн байцаагчийн хүлээн зөвшөөрсөн огноогоор гаалийн мэдүүлэгт тусган тоо хэмжээг гаргадаг;
- ТЕГ нь ашигт малтмалын бүтээгдэхүүнийг олборлосон хүдэр, үйлдвэрлэсэн, ачуулсан, борлуулсан бүтээгдэхүүний тоо хэмжээг<sup>5</sup> АМНАТ төлөгчийн улирал тутам өссөн дүнгээр гаргаж, дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн дүнг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус тайлагнаж ирүүлснээр<sup>6</sup> ашигт малтмалын бүтээгдэхүүний чийгшил хассан, цэвэр металлд шилжүүлсэн<sup>7</sup> байдлаар гаргадаг;
- АМГТГ-ын хувьд уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй ААНБ-ууд жил бүрийн уулын ажлын тайланг дараа жилийн 2 дугаар сарын 15-ны дотор<sup>8</sup> батлагдсан маягтын дагуу<sup>9</sup> гарган ирүүлдэг боловч хугацаандаа ирүүлээгүй тохиолдолд хэрхэх талаар нарийвчилсан зохицуулалт байхгүй байна.

1.20. Энэ нь эрдэс баялгийн бүтээгдэхүүний олборлосон, ашигласан, худалдсан, худалдахаар ачуулсан болон экспортлолсон тоо хэмжээнд үндэслэн гаргадаг Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөрийн<sup>10</sup> тайлагнасан тоо хэмжээ, дүнг хянахад хүндрэл учруулдаг тул цаашид холбогдох төрийн байгууллагууд цахим системээр холбогдон уул уурхайн бүтээгдэхүүний экспортын мэдээлэл солилцож, дүн мэдээг нягтлах ажлыг сайжруулах шаардлагатай байна

<sup>4</sup> ГЕГ-ын даргын 2019 оны А/275 дугаар тушаалаар баталсан “Гаалийн хилээр нэвтрүүлэх бараа, тээврийн хэрэгсэлд гаалийн хяналт тавих нийтлэг журам”

<sup>5</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 47.2-т Энэ хуулийн 47.16-д заасан борлуулалтын үнэлгээг дараах журмаар тооцно:

<sup>6</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 47.11-д Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан хувь хүнээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь тухайн улиралд олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөрийн нийт хэмжээг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гаргаж, улирлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.

<sup>7</sup> Засгийн Газрын 2019 оны 465 дугаар тогтоол

<sup>8</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 48.1.2-т хайгуулын ажлын жилийн тайланг төрийн захиргааны байгууллагаас баталсан зааврын дагуу гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны өдрийн дотор;

<sup>9</sup> Ашигт малтмалын тухай хуулийн 48.11-т Энэ хуулийн 48.6.2, 48.6.3-т заасан маягыг төрийн захиргааны байгууллагын дарга батална.

<sup>10</sup> Агаарын бохирдлын тухай хуулийн 5.1-т Олборлосон түүхий нүүрс, үйлдвэрлэсэн болон импортлолсон органик уусгагч, автотээврийн болон өөрөө явагч хэрэгсэл, агаарын бохирдлын томоохон суурин эх үүсвэрээс агаарт гаргах хаягдалд агаарын бохирдлын төлбөр /цаашид “төлбөр” гэх/ ногдуулна.

## БҮЛЭГ ХОЁР. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГУУД ХООРОНDOO МЭДЭЭЛЛИЙГ ТОГТМОЛ СОЛИЛЦСОНООР АШИГТ МАЛТМАЛЫН НӨӨЦ АШИГЛАСНЫ ТӨЛБӨРИЙГ БҮРЭН НОГДУУЛЖ, ТӨСВИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЭХ БОЛОМЖТОЙ БАЙНА

**Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөний талаар холбогдох хууль, журамд заасны дагуу төрийн байгууллагууд тухай бүр харилцан мэдээлэл солилцоогүй байна.**

2.1. Ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн шилжилт хөдөлгөөн хийгдсэн тухай бүр АМГТГ-аас АМТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.12<sup>11</sup>, 49 дүгээр зүйлийн 49.11<sup>12</sup>, 49.12<sup>13</sup>, ХЭУБТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6<sup>14</sup>, ААНОАТТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2<sup>15</sup>, Сангийн сайдын 2019 оны 302 дугаар тушаалаар баталсан “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”, мөн “Ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах журам”-ын дагуу мэдээлснийг үндэслэж ТЕГ-аас ААНБ-ын татвар ногдох орлогыг тооцохоор зохицуулсан байна.

2.2. Тайлант хугацаанд давхардсан тоогоор 503 тусгай зөвшөөрөл эзэмшигч бүхий иргэн, аж ахуй нэгжийн 172 ашиглалтын, 451 хайгуулын тусгай зөвшөөрлийг хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлснээр нийт 43,366.4 сая төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 5. Тусгай зөвшөөрлийн 2019-2022 онд хийсэн шилжилт хөдөлгөөний татвар төлөлтийн мэдээ

Он	Тусгай зөвшөөрлийн тоо		ААН-ийн тоо /давхардсан тоогоор/	Татвар ногдуулсан орлогын дүн, сая төгрөг
	Ашиглалт	Хайгуул		
2019	50	148	123	7,836.8
2020	52	101	138	18,085.4
2021	37	84	112	8,070.6
2022	33	118	130	9,373.6
Нийт	172	451	503	43,366.4

Эх сурвалж: ТЕГ

2.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнийг АМГТГ-т мэдээлж, бүртгүүлээгүй байна. Үүнд: 2019 онд 10, 2020 онд 11, 2021 онд 9, 2022 онд 4 хуулийн этгээд байна. /Хавсралт 2/

2.4. Энэ нь АМТХ-ийн 35 дугаар зүйлийн 35.12-д “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хаяг, цахим шуудан, утас... дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ” гэсэн заалттай бүрэн нийцээгүй байна.

2.5. АМГТГ-т тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжийн зөвшөөрлийг хэсэгчлэн болон бүхэлд нь шилжүүлсэн бүртгэл хийгдсэн байхад ТЕГ-т шилжилт хөдөлгөөнийг бүртгээгүй, татвар ногдуулаагүй байна. Үүнд: 2019 онд 3, 2020 онд 4, 2022 онд нэг тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. /Хавсралт 3/

2.6. УБЕГ-т 30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэлд өөрчлөлт орж тодорхойлолт /татварын өргүй талаарх тодорхойлолт/-той бүртгэгдсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч бүхий ААН-ийн мэдээлэл нь ТЕГ-т бүртгэгдээгүй, татвар ногдуулаагүй байна. Үүнд: 2019 онд 2, 2021 онд 4, 2022 онд 3 иргэн, ААНБ байна. /Хавсралт 4/

<sup>11</sup> “Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрийн хаяг, цахим шуудан, утас, факсны дугаар өөрчлөгдсөн тохиолдолд 14 хоногийн дотор төрийн захиргааны байгууллагад мэдэгдэнэ”,

<sup>12</sup> “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл шилжүүлснийг бүртгэсэн талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ”,

<sup>13</sup> “Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасан эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээд энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-д заасны дагуу харьяа татварын албанд мэдэгдэнэ”

<sup>14</sup> “Хуулийн этгээдийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөрчлөлтийг бүртгэнэ”,

<sup>15</sup> “Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно”



2.7. УБЕГ-т 30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн мэдээлэлд өөрчлөлт орж тодорхойлолтгүй бүртгэгдсэн тусгай зөвшөөрөл эзэмшигч бүхий ААН-ийн мэдээлэл ТЕГ-т бүртгэгдээгүй, татвар ногдуулаагүй байна. Үүнд: 2019 онд 34, 2020 онд 46, 2021 онд 46, 2022 онд 52 тусгай зөвшөөрөл эзэмшигч байна. /Хавсралт 5/

2.8. Энэ нь АМТХ-ийн 49 дүгээр зүйлийн 49.11-д “Төрийн захиргааны байгууллага тусгай зөвшөөрөл шилжүүлснийг бүртгэсэн талаар татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтэлнэ”, 49.12-т “Татварын ерөнхий хуулийн 6.1.48-д заасан эцсийн эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдолд хуулийн этгээд энэ хуулийн 49.4.8-д заасан баримт бичгийг Татварын ерөнхий хуулийн 26.10, 26.11, 26.12-д заасны дагуу харьяа татварын албанд мэдэгдэнэ”, ААНОАТТХ-ийн 30 дугаар зүйлийн 30.2-т “Эцсийн эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийг борлуулах, шилжүүлэх замаар олгосон газар эзэмших, ашиглах эрх, ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийг бүрэн буюу хэсэгчлэн борлуулах, шилжүүлэхтэй холбогдон олсон орлогыг тухайн эрх эзэмшигч аж ахуйн нэгжийн энэ хуулийн 10.1.2-т заасан орлогод тооцно” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

2.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигч ААНБ татвар төлж, шилжилт хөдөлгөөн хийгдсэн боловч УБЕГ-т бүртгэл хийгдээгүй байна. Үүнд; 2019 онд 45, 2020 онд 47, 2021 онд 38, 2022 онд 50 ААНБ байна. /Хавсралт 6/

2.10. Энэ нь ХЭУБТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Хуулийн этгээдийн мэдээлэл өөрчлөгдсөн тохиолдолд улсын бүртгэлийн байгууллага холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолтыг үндэслэн өөрчлөлтийг бүртгэнэ” гэсэн заалттай бүрэн нийцэхгүй байна.

2.11. Дээрх байдлаас үзэхэд холбогдох төрийн байгууллагуудын ажлын уялдаа холбоо хангагдаагүй, мэдээлэл зөрүүтэй тусгай зөвшөөрөл эзэмшигч иргэн, ААНБ-ууд хуульд заасан үүргээ бүрэн биелүүлээгүй, хяналтын тогтолцоо хангалтгүй байна.

2.12. Уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ууд 2019-2022 онд нийт 12,577.0 тэрбум төгрөгийн татварын ногдуулалт хийсэн бөгөөд ААНОАТ 4,001.9 тэрбум төгрөг буюу 31.8 хувь, НӨАТ 710.2 тэрбум төгрөг буюу 5.6 хувь, ХХОАТ 524.3 тэрбум төгрөг буюу 4.2 хувь, АМНАТ 6,921.2 тэрбум төгрөг буюу 55.0 хувь, бусад 419.0 тэрбум төгрөг буюу 3.3 хувь тус тус эзэлж байна.

2.13. Ногдуулсан татварын хэмжээ 2019 оноос 2022 онд нийт дүн 2,278.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээс ААНОАТ 644.2 тэрбум төгрөгөөр, НӨАТ 58 тэрбум төгрөгөөр, ХХОАТ 72.9 тэрбум төгрөгөөр, АМНАТ 1,432.5 тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

Хүснэгт 6. Эрдэс баялгийн салбарын татварын ногдуулалтын судалгаа, тэрбум төгрөг

Татварын төрөл	2019 он	2020 он	2021 он	2022 он	Дүн
ААНОАТ	929.6	699.6	798.7	1,573.8	4,001.7
НӨАТ	154.7	167.8	174.8	212.7	710.0
ХХОАТ	98.0	133.2	122.0	170.9	524.1
АМНАТ	1,209.5	1,277.2	1,792.5	2,642.0	6,921.2
Газрын төлбөр	-	37.3	37.6	44.6	119.5
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	11.8	35.2	46.1	60.8	153.9
Агаарын бохирдлын төлбөр	49.7	34.2	25.2	24.6	133.7
АТБӨЯХАТ	1.3	1.3	1.5	1.5	5.6
Ус бохирдуулсны төлбөр	-	0.1	0.2	1.9	2.1
Бусад	1.3	1.1	0.7	1.3	4.4
<b>Нийт дүн</b>	<b>2,455.9</b>	<b>2,387.0</b>	<b>2,999.3</b>	<b>4,734.1</b>	<b>12,576.2</b>

Эх сурвалж: ТЕГ

2.14. АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.11<sup>16</sup> дахь заалтын дагуу татвар төлөгч АМНАТ-ийн тайланг ТЕГ-ын даргын тушаалаар баталсан маягтын дагуу улирал тутам болон жилийн

<sup>16</sup> Монголбанк, түүнээс эрх олгосон арилжааны банканд алт тушаасан хувь хүнээс бусад энэ хуулийн 47.1-д заасан ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь тухайн улиралд олборлож худалдсан, худалдахаар ачуулсан, ашигласан ашигт малтмалын тоо хэмжээ, борлуулалтын үнэлгээ, төлбөрийн нийт хэмжээг, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас баталсан маягтын дагуу улирал тутам өссөн дүнгээр гарааж, улсрлын тайланг дараагийн улирлын эхний сарын 20-ны өдрийн дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ.

эцэст нэгтгэн тайлагнадаг бөгөөд уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг татвар төлөгчийн нийт татварын ногдуулалтын 55 хувийг АМНАТ эзэлж байна.

2.15. АМНАТ-ийн ногдуулалтын хэмжээ жил бүр өссөн үзүүлэлттэй байгаа бөгөөд 2019 оноос 2022 онд 1,432.5 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.16. Энэхүү өсөлт нь Ашигт малтмалын тухай хуульд 2019 онд нэмэлт өөрчлөлт орон ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэггүй экспортлогчид /265 ААНБ/ төлбөр төлөгчөөр бүртгэгдсэн нь нөлөөлсөн байна.

2.17. Аудитад хамрагдсан хугацаанд нийт 6,921.2 тэрбум төгрөгийн АМНАТ-ийн ногдуулалт хийснээс 6,605.5 тэрбум төгрөг буюу 95.4 хувь нь экспортод гаргасан ашигт малтмал, 315.9 тэрбум төгрөг буюу 4.6 хувь нь дотоодод борлуулсан ашигт малтмал эзэлж байна.

2.18. Аудитад давхардсан тоогоор 518 татвар төлөгчийн АМНАТ-ийн тайланг хамруулан ГЕГ-ын экспорт, импортын мэдүүлэг, гаалийн лабораторийн дүгнэлт, Сангийн яамны олон улсын зах зээлийн үнэ, Монголбанкнаас зарласан сарын дундаж ханшийн мэдээлэл зэргийг тулган шалгалаа.

2.19. Нийт 99 татвар төлөгчийн 2021-2022 оны 23,363 гаалийн мэдүүлгийг тулгахад 2,130 гаалийн мэдүүлгийн дүн нь АМНАТ-ийн ногдуулсан дүнгээс нийт 8.3 тэрбум төгрөгөөр зөрүүтэй буюу дутуу тайлагнасан байна.

2.20. ААНБ-ын 2019-2022 оны экспортолсон ашигт малтмалын гаалийн мэдээг АМНАТ-ийн тайлангийн тоо хэмжээтэй тулгахад 646.9 мянган тонн ашигт малтмалыг тайлагнаагүй, 412.7 мянган тонн ашигт малтмалыг зөрүүтэй тайлагнасан байна. Үүнд:

- 2019 онд 31 татвар төлөгч 341.6 мянган тонн, 2022 онд 34 татвар төлөгч 305.3 мянган тонн нийт 646.9 мянган тонн ашигт малтмалыг экспортод гаргасан боловч АМНАТ-ийн тайланд тусгаагүй;
- 2019 онд 10 татвар төлөгч 217.6 мянган тонн, 2020 онд 6 татвар төлөгч 121.8 мянган тонн, 2021 онд 12 татвар төлөгч 66.3 мянган тонн, 2022 онд 8 татвар төлөгч 6.8 мянган тонн, нийт 412.7 мянган тонн ашигт малтмалын тоо хэмжээг дутуу тайлагнасан байна.

2.21. Татварын алба нь 2022 онд МХЕГ-тай хамтран 85 АМНАТ төлөгчийн 2018-2021 оныг хамруулан татварын хэсэгчилсэн хяналт шалгалтыг тусгай удирдамжийн дагуу зохион байгуулж, уг ажлын үр дүнд 1,900.0 тэрбум төгрөгийн зөрчил илрүүлж 96.3 тэрбум төгрөгийн нөхөн татвар нийт 151.6 тэрбум төгрөгийн төлбөр ногдуулсан байна.

2.22. АМНАТ-ийн өсөн нэмэгдэх хувийг Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.5, 47.17 дахь заалтаар зах зээлийн үнийн өсөлт, боловсруулалтын түвшнээс хамаарч нэмэгдүүлэн тооцож байгаа бөгөөд Засгийн Газрын 2019 оны 465 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 3.2<sup>17</sup>-т заасны дагуу ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг бүтээгдэхүүн ангиллын хувь хэмжээгээр тус тус тооцдог байна.

2.23. УАГ-ын 2019 оны УАГ-ГАГ/2019/06-ГА код бүхий “Экспортод гаргаж буй зарим нэрийн ашигт малтмалын олборлолт, борлуулалт, үнэ, ашиг, алдагдал” сэдэвт гүйцэтгэлийн аудитын зөвлөмж, олон улсын зах зээл дэх эрдэс баялгийн бүтээгдэхүүний үнийн өсөлт, эрэлт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд татварын албаны хийсэн судалгаа, гаргасан саналыг үндэслэн 2021 онд 174 дүгээр тогтоолыг Засгийн газрын хуралдаанаар батлуулан хэрэгжүүлснээр өмнө нь нүүрс болон төмрийн хүдрийн бүтээгдэхүүний АМНАТ-ийг гэрээний дүн /олон улсын зах зээлийн үнээс даруй 30 хүртэлх хувиар бага/ -ээр тайлагнадаг байсан 25 ААНБ-ын АМНАТ-ийг олон улсын зах зээлийн жишиг үнээр тайлагнуулдаг болсонтой холбоотойгоор 2021 оны 7 дугаар сарын 01-ээс 2022 оны 6 дугаар сарын 30-ны хооронд экспортолсон бүтээгдэхүүнд ногдох АМНАТ-ийн ногдлыг 300.5 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

<sup>17</sup> Ашигт малтмалын бүтээгдэхүүнд дагалдах металл болон эрдэс бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны нэмэлт төлбөрийг Ашигт малтмалын тухай хуулийн 47.5 дахь хэсэгт заасан боловсруулалтын түвшний “бүтээгдэхүүн” ангиллын хувь хэмжээгээр, 47.17 дахь хэсэгт заасан бүтээгдэхүүний нэр төрлийн “эцсийн бүтээгдэхүүн” ангиллын хувь хэмжээгээр тус тус тооцож ногдуулна.

2.24. Ашигт малтмалын АМНАТ-ийг тооцох борлуулалтын үнэлгээг Сангийн яамнаас зарладаг сар бүрийн экспортод гаргасан ашигт малтмалын бүтээгдэхүүний олон улсын зах зээлийн дундаж үнэ, Монголбанкнаас зарласан үнэт металлын сарын дундаж ханшийг үндэслэн тогтоодог байна.

2.25. АМНАТ-ийн тайлангийн ТТ-15Б маягтын дагуу боловсруулаагүй нүүрс экспортолсон 82 татвар төлөгчийн ногдох борлуулалтын үнэлгээ, тооцооллыг гаалийн байгууллагын мэдүүлэгтэй тулгахад 2021 оны 7-12 сарын хугацаанд 9 татвар төлөгч (мэдүүлгийн тоо 5746) үнэлгээг гэрээний үнээр тооцож тайлагнасан байна.

2.26. Татварын албанаас дээрх 9 татвар төлөгчийн АМНАТ-ийн тайланг АМТХ-ийн 47-р зүйл, Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын дагуу зөв тайлагнуулахаар буцаасан байна.

2.27. Татварын ерөнхий хуулийн 30-р зүйлд зааснаар АМНАТ-ийн тайлангаа залруулж ирүүлээгүй тул зарим татвар төлөгчийг 2022 онд татварын хяналт шалгалтад хамруулж, нийт 0.6 тэрбум төгрөгийн төлбөрийг ногдуулсан ба үлдсэн татвар төлөгчдийг 2023 онд хяналт шалгалтад хамруулахаар төлөвлөсөн байна.

2.28. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1<sup>18</sup> дэх заалтын дагуу түүхий нүүрс олборлосон хэмжээг үндэслэн агаарын бохирдлын төлбөр ногдуулдаг байна. Тухайлбал:

- Нүүрсний агаарын бохирдлын төлбөрт 2019 онд 36 татвар төлөгч 39.1 тэрбум төгрөгийн, 2020-2022 онд нийт 133 татвар төлөгч 111.0 тэрбум төгрөгийн ногдуулалтыг тооцож тайлагнасан;
- Засгийн Газрын 2012 оны 227 тогтоолын дагуу 17 татвар төлөгчийг 2019-2021 онд нүүрсний агаарын бохирдлын 2.6 тэрбум төгрөгийн төлбөрөөс хөнгөлж, 4 татвар төлөгчийн 36.0 тэрбум төгрөгийг чөлөөлсөн байна.

**Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллагууд төсвийн орлогын дийлэнх хувийг бүрдүүлдэг хэдий ч татварын хуримтлагдсан өртэй байна.**

2.29. Татварын албанд улсын хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн байдлаар нийт 244346 татвар төлөгч хуулийн этгээд бүртгэлтэй байгаагаас уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй тусгай зөвшөөрөлтэй 846, тусгай зөвшөөрөлгүй 266, үүсмэл ордын 1 нийт 1113 татвар төлөгч хуулийн этгээд байна.

2.30. Эдгээрийг татварын албаар нь ангилбал Том татвар төлөгчийн газарт 315, аймгийн татварын албанд 447, Нийслэлийн татварын газарт 169, дүүргийн татварын хэлтэст 182 татвар төлөгч тус тус харьяалагдаж байна.

2.31. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа эрхлэгч татвар төлөгчийн 2019-2022 онуудын татварын тайлангийн ирцийг авч үзвэл ААНОАТ 92.5-96.7 хувь, НӨАТ 92.0-97.6 хувь, АМНАТ 67.9-89.5 хувь, ХХОАТ 79.6-80.8 хувьтай байна.

Хүснэгт 7. Татвар төлөгчийн тайлангийн 2019-2022 оны ирцийн судалгаа, тоо

№	Татварын төрөл	2019 он			2020 он			2021 он			2022 он		
		ИЗ	Ирсэн	Хувь	ИЗ	Ирсэн	Хувь	ИЗ	Ирсэн	Хувь	ИЗ	Ирсэн	Хувь
1	ААНОАТ	1031	992	96.2%	1063	984	92.5%	1094	1058	96.7%	1113	1046	93.9%
2	НӨАТ	605	557	92%	627	611	97.4%	643	611	95.0%	652	637	97.6%
3	АМНАТ	1033	704	67.9%	1065	829	77.8%	1096	923	84.2%	1113	997	89.5%
4	ХХОАТ	1277	1017	79.6%	1312	1050	80.0%	1343	1082	80.5%	1360	1099	80.8%

Эх сурвалж: ТЕГ-ын мэдээлэл, жич: ИЗ – Ирүүлбэл зохих

2.32. АМНАТ төлөгчийн 2019/2022 оны тоог харьцуулахад тайлан ирүүлбэл зохих тоо 80 татвар төлөгчөөр, тайлан ирүүлсэн татвар төлөгчийн тоо 293 татвар төлөгчөөр тус тус нэмэгдэж, тайлан ирүүлээгүй татвар төлөгчийн тоо 213-аар буурсан үзүүлэлттэй байна.

<sup>18</sup> Олборлосон түүхий нүүрсний төлбөрийн хувь, хэмжээг нүүрсний килограмм тутамд 1-2 төгрөгийн хязгаарт багтаан Засгийн газар тогтооно.



2.33. Татварын албанаас тайлангаа хугацаандаа ирүүлээгүй татвар төлөгчдөд утсаар мэдэгдэх, мэйл хүргүүлэх, гар утсаар масс мессеж илгээх зэрэг арга хэмжээ авч ажиллаж байгаа боловч дээр дурдсан татвар төлөгчдийн АМНАТ-ийн тайланг бүрэн хүлээн аваагүй байна.

2.34. Татвар төлөгчид тайлангаа хугацаандаа ирүүлээгүй шалтгааныг тодорхойлж, хугацаандаа ирүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах шаардлагатай байна.

2.35. АМНАТ-ийн тайлан ирүүлсэн байдлыг 2019-2022 онуудаар авч үзвэл “х” тайлан ирүүлсэн татвар төлөгчийн эзлэх хувь 14.4-24.6 хувь, “алдагдалтай” тайлан ирүүлсэн татвар төлөгчийн эзлэх хувь 39.7-50.9 хувь тус тус байна.

**Хүснэгт 8. Татвар төлөгчийн “х” болон “Алдагдалтай” тайлангийн судалгаа**


Уул уурхайн салбарын татвар төлөгчийн нийт тоо	“Х” тайлан				“Алдагдалтай” тайлан			
	2019 он	2020 он	2021 он	2022 он	2019 он	2020 он	2021 он	2022 он
<b>Татвар төлөгч 1'113</b>	182	267	274	161	536	442	475	567
<b>Хувь</b>	16.3%	23.9%	24.6%	14.4%	48.1%	39.7%	42.6%	50.9%

Эх сурвалж: ТЕГ

2.36. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа эрхлэгч татвар төлөгчийн ирүүлсэн тайланг хүлээн авах явцад Татварын ерөнхий хуулийн 15 дугаар зүйлийн 15.1<sup>19</sup>-д заасны дагуу 2019-2022 онд зарим татвар төлөгчийн 396.0 тэрбум төгрөгийн алдагдалтай тайлан ирүүлснийг 38.7 тэрбум төгрөг болгон баталгаажуулжээ.

2.37. Уул уурхайн салбарын татварын орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл 2019-2022 онд нийт 12,898.2 тэрбум төгрөг төвлөрүүлснээс ААНОАТ 4,169.6 тэрбум төгрөг, АМНАТ 6,592.6 тэрбум төгрөг, НӨАТ 560.2 тэрбум төгрөг, ХХОАТ 593.6 тэрбум төгрөг, бусад татвар хураамж 982.2 тэрбум төгрөг тус тус байна.

**Зураг 1. Татварын нэр төрлөөр орлогын 2019-2022 оны судалгаа, тэрбум төгрөг**



2.38. Хүснэгтээс үзэхэд 2019-2022 онд татварын нэр төрлөөрх нийт орлогод АМНАТ 44.4-60.5 хувийг, улсын төсвийн нийт орлогод 10.1-13.7 хувийг тус тус эзэлж байна.

**Хүснэгт 9. Төсвийн орлогын 2019-2022 оны бүрдүүлэлт, тэрбум төгрөг**

Төсвийн орлого	2019 он	2020 он	2021 он	2022 он
Уул уурхайн салбарын орлого	2,635.1	2,365.7	3,707.8	4,189.6
АМНАТ	1,350.1	1,051.2	1,652.7	2,538.7
Төсвийн орлогод эзлэх хувь	21.9%	22.6%	25.9%	22.6%
Төсвийн орлогод АМНАТ-ийн эзлэх хувь	11.2%	10.1%	11.5%	13.7%
<b>Дүн</b>	<b>12,040.3</b>	<b>10,442.2</b>	<b>14,306.4</b>	<b>18,521.6</b>

Эх сурвалж: ТЕГ

2.39. Уул уурхайн салбарын үйл ажиллагаа эрхлэгч татвар төлөгчдийн татварын өр болон тайлангийн дутуу төлөлтийн судалгааг авч үзэхэд татварын албаны хэмжээнд 2023 оны 04 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 3,276.7 тэрбум төгрөгийн татварын өр, тайлангийн ногдлын дутуу үлдэгдэлтэй байгаагаас уул уурхайн салбарын татвар төлөгчдийн татварын өр, тайлангийн ногдлын дутуу үлдэгдэл 1,152.8 тэрбум төгрөг буюу нийт татварын албаны өр төлбөрийн 35.2 хувийг эзэлж байна.

<sup>19</sup>Татварын нөхөн ногдуулалт хийх, алданги, торгууль ногдуулах, хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэх, алдагдал шилжүүлэх, нэмэгдсэн өртгийн албан татварын ногдуулалт, төлөлтийг баталгаажуулах хөөн хэлэлцэх хугацаа 4 жил байх бөгөөд Иргэний хуульд заасан хөөн хэлэлцэх хугацаа татварын хууль тогтоомжид хамаарахгүй.

## Хүснэгт 10. Тайлангийн болон хяналт шалгалтын өр төлбөрийн 2019-2022 оны мэдээлэл, тэрбум төгрөг

Үзүүлэлт	2019				2020				2021				2022			
	Тайлангийн		Хяналт шалгалтын		Тайлангийн		Хяналт шалгалтын		Тайлангийн		Хяналт шалгалтын		Тайлангийн		Хяналт шалгалтын	
	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу	Урд оны өр	Тайлант оны дутуу
Нийт өрийн дүн	80.5	67.8	8.2	28.6	148.3	251.5	36.8	14.1	399.8	1041.1	50.8	24.2	395.0	383.8	51	322.9
Үүнээс, АМНАТ-н өр	56.5	31.8	1.6	8.0	88.4	108.1	9.6	1.2	196.5	599.5	10.8	2.1	224.0	214.6	10.1	134.3
Нийт өрийн дүнд эзлэх хувь	70.2	46.9	19.5	28.0	59.6	43.0	26.1	8.5	49.1	57.6	21.3	8.7	56.7	55.9	19.8	41.6

Эх сурвалж: ТЕГ

2.40. Ковид-19 цар тахлаас шалтгаалж 2020-2021 онд Татварын ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн дагуу татвар төлөгчийн татварын өр барагдуулахтай холбоотой эд хөрөнгө битүүмжлэх болон дуудлага худалдаа зохион байгуулаагүй байна.

## Хүснэгт 11. Татвар төлөгчдийн өрийн барагдуулах үйл явцын мэдээлэл тэрбум төгрөг

Он	Өрийн нэхэмжлэх үүсгэсэн	Банкны данс битүүмжлэх мэдэгдэх хуудас хүргүүлсэн	Банкны дансны битүүмжлэл цуцлах мэдэгдэл хүргүүлсэн	Эд хөрөнгө битүүмжилсэн
2020	25.4	0.4	-	-
2021	1,626.7	450.1	0.7	-
2022	1,211.9	328.7	1,148.6	78.5

Эх сурвалж: ТЕГ

2.41. Газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээгээр олборлолт, ашиглалтын үйл ажиллагааг “Петрочайна Дачин Тамсаг” ХХК Дорнод аймгийн Тосон-Уул XIX, Тамсаг ХХI талбайд, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК Дорноговь аймгийн БХГ-97 талбайд үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд уг гэрээнд нөөц ашигласны төлбөрийн хувийг дараах байдлаар тусгасан байна.

## Хүснэгт 12. Бүтээгдэхүүн хуваах гэрээний заалт

Гэрээлэгч	Бүтээгдэхүүн хуваах гэрээний	
	зүйл заалт	заалтын утга
Петрочайна Дачин Тамсаг ХХК	Тосон Уул XIX 8.1 дэх зүйл. Төлбөр /Роялти/	Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг “Монголын газрын тос” компани Монголын Засгийн Газарт төлнө.
	Тамсаг ХХI 8.1 дэх зүйл. Төлбөр /Роялти/	Газрын тосны үйлдвэрлэлийн долоо аравны таван (7.5) хувийн төлбөрийг гэрээлэгч Монголын Засгийн газарт төлнө.
Доншен газрын тос, Монгол ХХК	БХГ-978.1 дэх зүйл. Төлбөр (роялти)	а) Хуанлийн улирал бүрд борлуулсан Гэрээт тосны үнийн хэмжээний долоо аравны таван (7.5) хувьтай тэнцэх хэмжээний төлбөрийг гэрээлэгч төлнө.

Эх сурвалж: УАГ

2.42. Газрын тосны үйл ажиллагаа эрхлэгч “Петрочайна Дачин Тамсаг” ХХК, “Доншен Газрын тос (Монгол)” ХХК-иуд нь 2019-2022 онд нийт 18.3 тэрбум төгрөгийн орлогыг улсын төсөвт төвлөрүүлсэн боловч 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт 414.8 тэрбум төгрөгийн өрийн үлдэгдэлтэй байгаа бөгөөд уг татварын өрийг барагдуулах талаар Татварын ерөнхий хуулийн 58 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хуулийн дагуу явуулсан ч, бүрэн хэрэгжээгүй байна.

2.43. Газрын тосны газар (хуучин нэрээр) гэрээлэгчийн нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхөгдсөн болон нөхөгдөх зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтыг хянан баталгаажуулах чиг үүргийг хэрэгжүүлж байсныг 2014 оны Газрын тосны тухай хуулиар Төрийн аудитын байгууллага аудит хийж баталгаажуулахаар шинэчлэн найруулсан.

2.44. Төрийн аудитын байгууллагаас 2020-2021 онд “Петрочайна Дачин Тамсаг” ХХК-ийн 2014-2018 оны батлагдсан төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ажил, нийт хөрөнгө оруулалт, өртөг нөхсөн болон нөхөгдсөн зардлын хэмжээ, газрын тосны экспорт, борлуулалтын орлогын тооцоо, хуваарилалтад аудит хийж баталгаажуулан, тайлан, албан шаардлага, зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.

2.45. Тус аудитаар Тосон Уул XIX талбайд байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөр (роялти) тооцож аваагүй нь БХГ байгуулах үед мөрдөгдөж байсан

Газрын тосны тухай хуулийн 9.1, 10.1 дүгээр зүйл, БХГ-ний 2.2 дахь заалтыг зөрчсөн гэж дүгнэсэн байна.

2.46. Иймд Тосон Уул XIX талбайн Бүтээгдэхүүн хуваах гэрээгээр 2014-2018 онд тус талбайгаас олборлосон газрын тосонд 5 хувиар буюу нийт 46.3 сая ам.долларын роялти нөхөн тооцоолж, гэрээлэгчээс Монгол Улсын Засгийн газарт 30.4 сая ам.долларыг нөхөн төлүүлэхээр баталгаажуулж, төлбөрийн акт тогтоосон бөгөөд хэрэгжилтийг дүгнэх хугацаа болоогүй байна.

2.47. Бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах үед хүчин төгөлдөр үйлчилж байсан Газрын тосны тухай хуульд нийцэхгүй байгаа зүйл заалтыг дурдвал:

*Хүснэгт 13.Тосон Уул XIX гэрээт талбайн БХГ-ний зүйл, заалтууд*

БХГ-ий зүйл, заалт	Газрын тосны тухай хууль/1991 он/	Тайлбар
БХГ-ний 2 дугаар зүйл. “Төлбөр (роялти) гэж Монгол улсын Газрын хэвлийн хууль болон Газрын тосны хуулийн дагуу байгалийн дахин сэргээгдэхгүй нөөц баялгийг ашигласны төлбөрийг хэлнэ. Энэ өртгийг олборлосон нийт бүтээгдэхүүнд ногдуулж, өртөгт тосыг хуваарилахаас өмнө төлнө.”	9 дүгээр зүйл. Гэрээлэгчид ногдуулах төлбөр, татвар 1.Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөрийг улсад төлнө. Төлбөрийн хэмжээг Монгол Улсын Засгийн газар тогтооно.	БХГ-ний 2 дугаар зүйлийн нэр томъёоны хэсэгт “роялти” заавал төлөх нөхцөлийг тодорхой тусгаж, өртөгт тосыг хуваарилахаас өмнө түүнийг хасаж тооцох тухай заасан нь хуульд нийцэж байна.
8 дугаар зүйл. Төлбөр ба бүтээгдэхүүн 8.1 “Төлбөр (роялти) Бүтээгдэхүүний аливаа төлбөр нь ашигт тосны монголын ногдол хэсэгт багтах бөгөөд түүнийг “Монголын газрын тос” Компани Монголын засгийн газарт төлнө.” 8.3.а. Хуанлийн сард ногдох өртөгт тосны нийт хэмжээг хасаад үлдсэн бүх гэрээт түүхий тосыг Монгол Улсын Засгийн газар болон гэрээлэгчийн хооронд тухайн хуанлийн сард гаргасан хуваах тосны өдрийн дундаж хэмжээнд тулгуурлан дор дурдсан харьцаагаар хуваана.	10 дугаар зүйл. Бүтээгдэхүүн хуваах 1.Гэрээлэгч нь газрын тос олборлосны төлбөр болон зардлаа нөхөх хэсгийг нийт олборлолтоос хасаад үлдсэн бүтээгдэхүүнийг газрын тосны хэрэг эрхлэх байгууллагатай хуваана. Бүтээгдэхүүн хуваах хувь хэмжээг хоногт гаргаж байгаа газрын тосны хэмжээтэй уялдуулан тохиролцож газрын тосны тухай гэрээнд тодорхойлон заана.	Газрын тосны тухай хуулийн 10 дугаар зүйлд газрын тос олборлосны төлбөрийг нийт олборлолтоос эхэлж хасах, дараа нь өртөгт зардал хасах, үлдсэнийг хуваах журмыг тодорхой заасан. Гэвч БХГ-ний 8.1 ба 8.3 дахь заалтууд нь хуульд нийцэхгүй байна. Энэ тохиолдолд хуулийг давуу байдлаар хэрэглэнэ. Хэрэв хуулийг баримталбал нийт олборлосон тосноос эхлээд төлбөр, дараа нь өртөгт тосыг хасаад үлдсэнийг талуудад хуваах ёстой.

Эх сурвалж:УАГ

2.48. Иймд уул уурхай, газрын тосны салбарын бодлого, хууль эрх зүйн орчныг шинэчлэх замаар бүтээгдэхүүн хуваах гэрээний нөхцөлүүдийг нийцүүлэн өөрчлөх шаардлагатай байна.

***Зарим ордын нөөцөд бүртгэсэн болон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалыг иж бүрэн үнэлэх хууль эрхзүйн орчин дутмаг байна***

2.49. Хайгуулын ажлаар тогтоогдсон геологийн нөөцийг АМГТГ /одоо Үндэсний геологийн алба/ бүртгэж авахдаа дагалдах ашигт малтмалыг бүртгэдэг боловч техник эдийн засгийн үндэслэл боловсруулахад хэрэглэдэг эдийн засгийн ач холбогдол бүхий үйлдвэрлэлийн нөөцийн хувьд тухайн боловсруулалтын техник, технологийн шугам тавигдаагүй бол энэхүү үндэслэлийг тооцоололд оруулдаггүй, олборлогч болон боловсруулагч ААНБ нь худалдан борлуулах гэрээнд зөвхөн үндсэн ашигт малтмалыг тусгаж, дагалдах ашигт малтмалыг тусгалгүй орхигдуулдаг.

2.50. Татварын ерөнхий газар<sup>20</sup> нь АМТХ-ийн 47 дугаар зүйлийн 47.16, Засгийн газрын 2019 оны 465 дугаар тогтоолоор баталсан “Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн хувийг тооцох, төлбөр ногдуулах, тайлагнах, төлөх журам”-ын 2.4-т “Гадаадын зах зээлд борлуулж байгаа бүх төрлийн ашигт малтмалын бүтээгдэхүүний агуулга, түүний хувь, шинж чанар, ангиллыг Гаалийн лабораторийн дүгнэлтэд үндэслэн тодорхойлно” гэж заасны дагуу гаалийн мэдүүлгийн барааны тодорхойлолт хэсэгт байгаа ашигт малтмал, металлын төрөл тус бүрд АМНАТ ногдуулдаг байна.

2.51. Дараах нэр төрлийн дагалдах ашигт малтмалд 2022 онд ногдуулсан АМНАТ дараах байдалтай байна. Үүнд:

- Худалдан авсан 32.8 тэрбум төгрөгийн алт, мөнгөний ногдуулалтаас 20.7 тэрбум төгрөг буюу 63.1 хувь, экспортод гаргасан жонш, хүдэр, төмөр, гянтболд зэрэг ашигт малтмалд

<sup>20</sup> Ашигт малтмалын 47.16Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр төлөгч нь бүх төрлийн ашигт малтмалын борлуулалтын үнэлгээнээс ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг энэ хуулийн 47.7-д заасны дагуу давхардуулалгүй ногдуулж улсын төсөвт төлнө

1,203.2 тэрбум төгрөгийн ногдуулалтаас 28.5 тэрбум төгрөг буюу 2.4 хувь, экспортод гаргасан бусад ашигт малтмалд 852.2 тэрбум төгрөгийн ногдуулалтаас 23.1 тэрбум төгрөг буюу 2.7 хувийг тус тус дагалдах ашигт малтмал эзэлж байна.

2.52. УАГ-аас 2019 онд “Экспортод гаргаж буй зарим нэрийн ашигт малтмалын олборлолт, борлуулалт, үнэ, ашиг, алдагдал”-д хийсэн гүйцэтгэлийн аудитаар зарим ордын нөөцөд бүртгэсэн, эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалыг иж бүрэн үнэлэх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Үүнд:

- Эрдэнэтийн овооны зэс-молибдений ордын нөөцийг тогтоосон комиссын хуралдааны тэмдэглэл<sup>21</sup>, лабораторийн шинжилгээний үр дүнгээр<sup>22</sup> илрүүлсэн мөнгө, рений;
- Төмөртийн овооны цайрын ордын нөөцийг тогтоосон комиссын хуралдааны тэмдэглэл<sup>23</sup>, лабораторийн шинжилгээний үр дүнгээр<sup>24</sup> илрүүлсэн кадми, индий зэрэг ашигт малтмалын бүтээгдэхүүний үнийг тус тус тооцоогүй байна.

2.53. АМНАТ-ийн тайлагналыг бүрэн цахим бүртгэлд шилжүүлснээр 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн Гаалийн төв лабораторийн дүгнэлтээр гарсан бүх төрлийн элементэд ногдол үүсдэг болсон нь татварын алба болон татвар төлөгчдийн хооронд маргаан үүсгэж байгаа нь үндсэн болон дагалдах ашигт малтмалын талаар хууль эрх зүйн орчныг бүрэн бүрдээгүйтэй холбоотой байна.

2.54. Иймд ашигт малтмалын ордын нөөцөд бүртгэсэн, үндсэн болон дагалдах ашигт малтмалын талаар хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах талаар геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон бусад холбогдох байгууллагууд анхаарч ажиллах шаардлага байна.

### Тогтворжуулалтын сангаас төсвийн алдагдлыг санхүүжүүлэхдээ холбогдох хуулийг мөрдөж ажиллаагүй байна.

2.55. Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлд “Төсвийн удирдлагын зарчим, төсвийн тусгай шаардлагад нийцсэн нэгдсэн төсвийн дунд, урт хугацааны тогтвортой байдлыг хангах зорилго бүхий Төсвийн тогтворжуулалтын сантай байна”, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 15 дугаар зүйлд “Төсвийн тогтворжуулалтын сан нь нэгдсэн төсвийн дунд болон урт хугацааны тэнцвэртэй, тогтвортой байдлыг хангах, төсвийн тэнцвэржүүлсэн горимыг хэрэгжүүлэхэд санхүүгийн хэрэгслийн үүрэг гүйцэтгэнэ” гэж заасан бөгөөд тус сан нь дараах эх үүсвэрээс орлогыг төвлөрүүлсэн байна. Үүнд:

- Татвар ногдуулж, төлүүлэхэд ашиглагдсан гол нэр төрлийн эрдэс баялгийн үнэ тухайн жилийн төсөвт тооцсон тэнцвэржүүлсэн үнээс өндөр байсны улмаас нэмэгдэж орсон төсвийн орлого;
- Засгийн газрын нөөц сангийн болон эрсдэлийн сангийн тухайн төсвийн жилийн зарцуулагдаагүй үлдэгдэл” зэрэг байна.

Хүснэгт 14. Төсвийн тогтворжуулалтын сангийн 2019-2022 оны орлого, зарлагын судалгаа, тэрбум төгрөг

Он	Эхний үлдэгдэл	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл	Зарлагын дүн	Эцсийн үлдэгдэл
2019 он	301.9	322.0	106.4	322.0	86.2
2020 он	86.2	55.2	52.4	138.6	
2021 он		612.8	623.9	728.8	
2022 он		751.7	1,394.6	751.7	663.3
<b>Нийт дүн</b>		<b>1,741.7</b>	<b>2,177.3</b>	<b>1,941.1</b>	

Эх сурвалж: УАГ

2.56. Тогтворжуулалтын сангийн 2019 оны эхний үлдэгдэл 301.9 тэрбум төгрөг байснаас 2019-2022 онд нийт 2,177.3 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 1,941.1 тэрбум төгрөгийг зарцуулж, 2022 оны жилийн эцэст 663.3 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.57. Тус сангаас нийт 1,941.1 тэрбум төгрөгийн улсын төсвийн алдагдалыг санхүүжүүлэхдээ шалгуур үзүүлэлтийг харгалзан үзээгүй нь Төсвийн тогтвортой байдлын

<sup>21</sup>Нөөцийг 1991 онд БНМАУ-ын ашигт малтмалын нөөцийн сангийн комиссын хамтарсан хуралдаанаар баталсан тэмдэглэлд “дагалдах ашигт малтмалын нөөцийг балансын харьяаллыг үл харгалзан 2 дугаар хавсралтаар баталж /1.84 грамм тоннын агуулга бүхий Мөнгө-2755.6 тонн, 0.13 грамм тонны агуулга бүхий 194.9 тонн Рений/, ...эдийн засгийн үнэлгээнд тусгах, үйлдвэрийн жил бүрийн үр дүнгээр дагалдах ашигт малтмал /мөнгө, рений, селен, пирит/-ын олборлолтын тооцоог гаргаж байх”

<sup>22</sup>Зэсийн баяжмалд алт 0.04 гр/тн, цайр 4900 гр/тн хүртэл, молибден 869.5 гр/тн хүртэл, кобальт 65.0 гр/тн, молибдений баяжмалд мөнгө 34.2 гр/тн, цайр 822.0 гр/тн хүртэл, рений 50 гр/тн түүнээс дээш, кобальт 22.0 гр/тн тус тус агуулагдаж байна.

<sup>23</sup>БНМАУ, БНАГУ, ЗСБНХУ-ын /хуучин нэрээр/ ашигт малтмалын нөөцийн комиссын хамтарсан хуралдаанаар баталсан тэмдэглэлд “ордын хүдэр 7193.2 мянган тонн, металл цайр 1101.04 мянган тонн, дагалдах ашигт малтмал болох кадмийн 0.0228 хувийн агуулгатай 2027 тонн, индийн 0.002 хувийн агуулгатай 218 тонн, 23.4 хувийн агуулгатай төмөр 1324.0 мянган тонн нөөцтэй гэж тооцсон байдаг”

<sup>24</sup>Цайрын баяжмалд кадми 879.0 гр/тн хүртэл, кобальт 392.0 гр/тн хүртэл, индий 128 гр/тн хүртэл агуулагдаж байна.

тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.3.1<sup>25</sup> дэх заалттай нийцэхгүй байгаа бөгөөд 2017.04.14-ний өдрийн хуулиар өөрчлөлт орж, уг заалтыг 2024.01.01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө" гэж заасан байна.

### Ирээдүйн өв сангийн батлагдсан төсвийг хэтрүүлэн хүүхдийн мөнгөн тэтгэмжид зарцуулжээ.

2.58. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2-т "Ашигт малтмалын тухай хуулийн 4.1.27-д зааснаас бусад орд ашигласнаас төсөвт төвлөрсөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрөөс Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн дагуу Төсвийн тогтворжуулалтын санд хуваарилаад үлдэх хэсгийн 65 хувь" гэж заасны дагуу орлогыг Ирээдүйн өв санд төвлөрүүлдэг байна.

Хүснэгт 15. Ирээдүй өв сангийн 2019-2022 оны орлого, зарлагын судалгаа, тэрбум төгрөг

Он	Сангийн эхний үлдэгдэл	Орлогын төлөвлөгөө	Орлогын гүйцэтгэл	Зарлагын дүн	Сангийн эцсийн үлдэгдэл
2019	101.8	1,068.5	953.0	516.3	538.6
2020	538.6	943.2	875.7	-	1,414.2
2021	1,414.2	1,062.4	1,151.7	-	2,565.9
2022	2,565.9	1,461.7	1,626.3	1,488.1	2,618.1
Нийт дүн		<b>4,535.8</b>	<b>4,606.7</b>	<b>2,004.4</b>	

Эх сурвалж: УАГ

2.59. Ирээдүйн өв сангийн 2019 оны эхний үлдэгдэл 101.8 тэрбум төгрөг байснаас 2019-2022 онд нийт 4,606.7 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, 2,004.4 тэрбум төгрөгийг зарцуулж, 2022 оны жилийн эцэст 2,618.1 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.60. Ирээдүйн өв сангийн тухай хуульд 2021 оны нэмэлт өөрчлөлтөөр "Хүүхдийн мөнгөн хуримтлал" гэсэн заалтыг шинээр нэмж, 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл дагаж мөрдөхөөр тусгасан байна.

2.61. Тус сангаас хүүхдийн мөнгөн төлбөрт 2022 онд нийт 1,488.1 тэрбум төгрөгийг зарцуулсан нь хуульд төлөвлөсөн зардлын дүнгээс 1,461.7 тэрбум төгрөг буюу 26.4 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

2.62. Ирээдүйн өв сангийн тухай хуулийн 5 дугаар заалтын дагуу хараат бус байх, ил тод байх, сангийн хөрөнгийг зохистой удирдах, сангийн хөрөнгийг үр ашигтай удирдах, хариуцлагатай байх зарчмуудыг мөрдөж ажиллах шаардлагатай байна.

<sup>25</sup> 16.3. Төсвийн тогтворжуулалтын сангийн хөрөнгөөс доор дурдсан санхүүжилт хийх зориулалтаар улсын төсөвт ишлжүүлж болно.



## Татварын ерөнхий газраас ирүүлсэн санал



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ  
ТАТВАРЫН ЕРӨНХИЙ ГАЗАР

Улаанбаатар хот, ЧД 4-р хороо,  
Бага тойруу /15160/, С.Данзангийн гудамж 4А,  
Утас: 7575-1288, E-mail: info@mta.gov.mn

2023.07.26 № 02/1655

танай 2023.07.07 -ны № 01/1330 -т

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ  
АУДИТОРЫН ОРЛОГЧИЙН АЛБАН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
Ц.НАРАНЧИМЭГ ТАНАА

### Санал хүргүүлэх тухай

Үндэсний аудитын газраас “Уул уурхайн салбарын төсвийн орлого бүрдүүлэлт, гүйцэтгэл” сэдвээр хийгдсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөл, асуудлын бүртгэлд санал авахаар ирүүлсэнтэй танилцаж, холбогдох саналыг хавсралтаар хүргүүлж байна.

ДЭД ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  АЭНХБОЛД



Татварын ерөнхий газрын 2023 оны 07  
дүгээр сарын 26 -ний өдрийн 02/1655  
албан бичгийн хавсралт

“УУЛ УУРХАЙН САЛБАРЫН ТӨСВИЙН ОРЛОГЫН БҮРДҮҮЛЭЛТ, ГҮЙЦЭТГЭЛ” (код:  
АНУЗГ-2023/22-ШТА-ГА) сэдэвт гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд санал

### ДҮГНЭЛТ-д найруулгын болон нэмэлт өөрчлөлт оруулах санал:

1. “Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтууд бүрэн хэрэгжээгүйгээс нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөллийг бууруулж байна.” гэснийг

Тайлбар 1-ийг  
үзнэ үү.

1. Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтод хүрэхэд шаардлагатай зарим хууль эрх зүйн өөрчлөлт, журам, аргачлал, БХГ-ны шинэчлэл хийгдээгүйгээс нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөөлөл буурсан байна” гэж өөрчлөх;

Тайлбар 2-ийг  
үзнэ үү.

“4. Аж ахуйн нэгж, байгууллагын ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтын байдлаар тавих дотоод хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүйгээс төсөвт төвлөрүүлэх орлого буурах эрсдэлтэй байна.” гэснийг хасах;

Тайлбар 3-ийг  
үзнэ үү.

6. “Хайгуулын явцад тогтоосон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын нөөцийг иж бүрэн бүртгээгүй, зарим ордын дагалдах ашигт малтмалын бүртгэгдсэн нөөцөд үнэлгээ хийж, дүгнэлт гаргаагүйгээс АМНАТ ногдуулах боломжийг алдсан байна.” гэснийг

6. “Хайгуулын явцад тогтоосон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын нөөцийг иж бүрэн бүртгээгүй, зарим ордын дагалдах ашигт малтмалын бүртгэгдсэн нөөцөд үнэлгээ хийж, дүгнэлт гаргаагүйгээс АМНАТ ногдуулах боломжийг бүрэн ашиглаж чадахгүй байна.” гэж өөрчлөх;

Тайлбар 4-ийг  
үзнэ үү.

#### Нэмэлтээр:

“8. Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2022 оны 362 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангуулах, татвар төлөгчдийг эрсдлээс урьдчилан сэргийлэх, АМНАТ болон бусад татварын ногдолыг бүрэн хийх зорилгоор 2022 оны 3 дугаар улиралаас АМНАТ-ийн ТТ-15 тайлангийн хавсралт мэдээг холбогдох төрийн байгууллага /Сангийн яам, Монгол банк, Гаалийн байгууллага/-уудын мэдээ, И-баримтын мэдээнд үндэслэн Татварын бүртгэл мэдээллийн нэгдсэн систем дээр цахим тооцоолуурт оруулах хөгжүүлэлтийг хийж 2022 оны 4 дүгээр улирлаас эхлэн Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайланг автоматжуулж, тайлан илгээхэд гараар хийгдэх үйлдэлгүй зөвхөн шинэчлэх товч дарахад АМНАТ-ын тайлан бэлгэгддэг болон нь татвар төлөгчийн, цаг хугацаа хэмнэсэн, үнэн зөв тайлагнах боломжийг бүрдүүлсэн, татвар төлөгчийг эрсдлээс хамгаалсан давуу талтай сайшаалтай ажил болсон байна.” гэж нэмж оруулах;

### ЗӨВЛӨМЖ-д найруулгын болон нэмэлт өөрчлөлт оруулах санал:

#### Сангийн сайдад:

“Төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, хяналт хэрэгжүүлэх нэгдсэн мэдээллийн системийг бий болгох технологийн шийдлийг холбогдох бодлогын яамтай хамтран боловсруулж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоогүй ажлуудыг талаар арва хэмжээ авч ажиллах.” гэснийг

Тайлбар 5-ийг  
үзнэ үү

“АМГТГ, УБЕГ, Татварын алба гэх мэт төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, хяналт хэрэгжүүлэх нэгдсэн мэдээллийн системийг бий болгох технологийн шийдлийг холбогдох бодлогын яамтай хамтран боловсруулж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоогүй ажлуудыг талаар арва хэмжээ авч ажиллах.” гэж өөрчлөх;

#### Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:

Тайлбар 6-г  
үзнэ үү.

- "АМГТГ, УБЕГ, Татварын алба гэх мэт төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох, хяналт хэрэгжүүлэх нэгдсэн мэдээллийн системийг бий болгох технологийн шийдлийг холбогдох бодлогын яамтай хамтран боловсруулж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах талаар арга хэмжээ авч ажиллах." гэж нэмж оруулах;

**Ашигт малтмал газрын тосны газрын даргад:**

Тайлбар 7-г  
үзнэ үү.

- "Ашигт малтмалын ордын нөөцөд бүртгэгдсэн эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалыг үнэлэх жишиг үнийг тооцох эрх зүйн орчныг шинэчлэх, хайгуулын явцад тогтоосон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын нөөцийг иж бүрэн бүртгэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох." гэснийг хасах

Тайлбар 8-ийг  
үзнэ үү.

- "Ашигт малтмалын тухай хуулийн тухай хуулийн Долдугаар бүлэг.Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх, барьцаалах. 49 дүгээр зүйл.Тусгай зөвшөөрлийг шилжүүлэх. 49.2-49.4 дүгээр заалтуудын дагуу бүрэн бүрдсэн материалыг геологи, уул уурхайн асуудал хариусан төрийн захиргааны байгууллагад өргөдлийн хамт өгснөөр шилжилт хөдөлгөөнийг хийж мөн хуулийн 49.11 дэх заалтад заасны дагуу Татварын албанд мэдэгдэх үүргийг тухай бүр хэрэгжүүлж ажиллах, гарсан зөрчлийг арилгах."

Тайлбар 9-ийг  
үзнэ үү

- "Тусгай зөвшөөрлийн төлбөрийг төлөх, төлөлт болон төлбөрийн баримтыг бүртгэх үйл ажиллагааны мэдээг татварын албатай харилцан солилцох ажлыг бүрэн цахимжуулах шаардлагатай."

Тайлбар 10-ийг  
үзнэ үү.

- "Газрын тосны тухай хуулиар БХГ-нд өөрчлөлт оруулах болон Газын тотны нөөц ашигласны төлбөр /ГНАТ/-ийг ногдуулан төсөвт төвлөрүүлэх үүрэг нь газрын тосны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад оногдсон учир хууль биелүүлж ажиллах"

- "Татварын албаны Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтын цахим системтэй ашиглалтын болон хайгуулын ажлын төлөвлөгөө, тайлангийн тоон мэдээлэл болон бусад мэдээллүүдийг цахимаар солилцох, эдгээр мэдээлэлтэй уялдуулж дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх." гэж нэмж оруулах;

**Татварын ерөнхий газрын даргад:**

Тайлбар 11-ийг  
үзнэ үү.

- "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг бусад төрийн байгууллагуудын мэдээ мэдээлэлтэй уялдуулж, мэдээллийг бодит цагийн горимоор авах боломжийг бүрдүүлж хэрэгжүүлэн, солилцсон мэдээллийн үнэн зөв, иж бүрэн, цаг хугацаандаа байгаа эсэхэд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх." гэснийг

- "Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг цахим систем болон бусад төрийн байгууллагуудын мэдээ мэдээлэлтэй уялдуулж, мэдээллийг бодит цагийн горимоор авах боломжийг бүрдүүлж хэрэгжүүлэн, солилцсон мэдээллийн үнэн зөв, иж бүрэн, цаг хугацаандаа байгаа эсэхэд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх." гэж өөрчлөх;

**Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргад:**

Тайлбар 12-ийг  
үзнэ үү.

- "Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хуулийн Гуравдугаар бүлэг.Хуулийн этгээдийн хувийн хэрэг. 10 дугаар зүйл. 10.6 дах заалтад заасны дагуу холбогдох татвар төлсөн талаарх татварын албаны тодорхойлолтыг үндэслэн Улсын бүртгэлийн байгууллага өөрчлөлтийг бүртгэж хэвшүүлэх, аудитаар гарсан зөрчлийг татварын байгууллагатай хамтран арилгах." гэж нэмж оруулах

Нэмэлтээр:

**Үндэсний геологийн албаны даргад:**

Тайлбар 13-ийг  
үзнэ үү.

- "Ашигт малтмалын ордын геологийн болон үйлдвэрлэлийн нөөцөд бүртгэгдсэн эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалыг үнэлэх жишиг үнийг тооцох эрх зүйн орчныг шинэчлэх ажилд санаачлага гарган, холбогдох яаманд санал хүргүүлж, шийдвэрлүүлэх, хайгуулын явцад тогтоосон эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын нөөцийг иж бүрэн бүртгэх ажлыг зохион байгуулж, үр дүнг тооцох, санал боловсруулж, шийдвэрлүүлэх." гэж нэмж оруулах;



## Үндэсний аудитын газрын тайлбар

### Тайлбар 1

Саналыг хүлээн авах боломжгүй тул мэдээллийг хэвээр үлдээв.

### Тайлбар 2

Саналыг хүлээн авах боломжгүй тул мэдээллийг хэвээр үлдээв.

### Тайлбар 3

Саналыг хүлээн авч дүгнэлтэд тусгав.

### Тайлбар 4

Уг асуудлыг “Татварын шинэчлэлийн бодлогын хэрэгжилт, түүний үр нөлөө”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланд тусгагдсан тул тайланд тусгах шаардлагагүй гэж үзлээ.

### Тайлбар 5

Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав.

### Тайлбар 6

Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав.

### Тайлбар 7

Саналыг хүлээн авч, зохих найруулгыг хийж, зөвлөмжид тусгав.

### Тайлбар 8

Уг асуудлыг санал 7-д тусгасан.

### Тайлбар 9

Үндэсний аудитын газраас уг асуудалтай холбоотой асуудалд албан шаардлагын холбогдох байгууллагад хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах талаар хяналт тавин ажиллаж байгаа тул зөвлөмжид тусгах шаардлагагүй гэж үзсэн.

### Тайлбар 10

Уг асуудлыг санал 5-д тусгасан.

### Тайлбар 11

Уг саналыг хүлээн авч, зохих найруулгыг хийж, зөвлөмжид тусгав.

### Тайлбар 12

Зөвлөмжийг хэвээр үлдээв.

### Тайлбар 13

Саналыг хүлээн авч зөвлөмжид тусгав.

## ДҮГНЭЛТ

Аудитын нотлох зүйл, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

1. Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгасан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт удааширсан нь баялгийн санд төвлөрүүлэх орлого буурахад нөлөөлжээ.
2. Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын тусгай зөвшөөрөл эзэмших, шилжүүлэх, бүртгүүлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь холбогдох төрийн байгууллагуудын тавих хяналт сул байгаатай холбоотой байна.
3. Уул уурхайн экспортын бүтээгдэхүүнээс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой тооцох мэдээллийн нэгдсэн системийг хөгжүүлснээр төрийн байгууллагууд харилцан мэдээлэл солилцох, ажлын уялдаа холбоо хангагдах боломжтой байна.
4. Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалт, тайлагналд тавих хяналтыг бүрэн хэрэгжүүлж, төсөвт төвлөрүүлэх нь орлогыг нэмэгдүүлэх боломжтой байна.
5. Эдийн засгийн ач холбогдол бүхий дагалдах ашигт малтмалын нөөцийг иж бүрэн бүртгээгүй, үнэлгээ хийж, дүгнэлт гаргаагүй нь татварын байгууллагаас АМНАТ ногдуулах боломжийг алдагдуулж байна.

## **ЗӨВЛӨМЖ:**

Аудитын дүн, дүгнэлт нотлох зүйлст үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна. Үүнд:

### **Сангийн сайдад:**

- Сангийн яам, Татварын ерөнхий газар, Ашигт малтмал, газрын тосны газар зэрэг байгууллагуудтай харилцан мэдээлэл солилцох, хяналт хэрэгжүүлэх мэдээллийн нэгдсэн системийг бий болгох технологийн шийдлийг холбогдох бодлогын яамтай хамтран боловсруулж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоог сайжруулахад чиглэсэн үр дүнтэй арга хэмжээ авч ажиллах.

### **Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдад:**

- Хууль эрх зүйн актад тусгасан уул уурхайн салбарыг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн зорилтуудыг бүрэн хэрэгжүүлэх, түүнд тавих хяналтыг сайжруулах, үр дүнг тооцож, тайлагнаж байх.
- Ашигт малтмал, газрын тосны газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Татварын ерөнхий газар зэрэг төрийн байгууллагуудын харилцан мэдээлэл солилцох ажлыг зохион байгуулах, ажлын уялдаа холбоог сайжруулах арга хэмжээ авч ажиллах.
- Ашигт малтмалын ордын геологийн болон үйлдвэрлэлийн нөөцөд бүртгэсэн, үндсэн болон дагалдах ашигт малтмалын талаар хууль эрх зүйн орчныг шинэчлэн сайжруулах талаар холбогдох яаманд санал хүргүүлж, шийдвэрлүүлэх.

### **Ашигт малтмал газрын тосны газрын даргад:**

- Ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг шинээр олгох, шилжүүлэх, эзэмшигч өөрчлөгдсөн тохиолдол тухай бүр холбогдох төрийн байгууллагуудад мэдээллийг хүргүүлж ажиллах.

### **Татварын ерөнхий газрын даргад:**

- Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн ногдуулалтыг бусад төрийн байгууллагуудын цахим системтэй уялдуулж, мэдээ мэдээллийг бодит цагийн горимоор авах боломжийг бүрдүүлж, солилцсон мэдээллийн үнэн зөв, иж бүрэн, цаг хугацаандаа байгаа эсэхэд дотоод хяналтыг тогтмол хэрэгжүүлэх.
- Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчдийг хуулиар хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлэх талаар мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн актыг зөрчсөн тохиолдолд хариуцлага тооцож ажиллах.

Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн биелэлт  
(2022 оны жилийн эцсийн байдлаар)

4.2.1. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, боловсруулалтын түвшин нэмэгдүүлнэ.				
Төсөл, арга хэмжээний нэр	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Аудитын үнэлгээ
Асгатын мөнгөний ордыг эдийн засгийн эргэлтэд оруулахад шаардлагатай туршилт, судалгааг хийж, хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх Салбарын яамнаас явсан бичиг зэрэг	Гүйцэтгэл 10 хувьтай байна.	Гүйцэтгэл 20 хувьд хүрсэн байна.	Цар тахалтай холбоотой төсөв хэмнэх Засгийн газрын чиглэлийн дагуу төсвийн санхүүжилт танагдсан. Мөн БНХАУ-ын Гашуун Сухайт, Ганц модны боомтын хил нэвтрүүлэлт эрс буурсантай холбоотой “Эрдэнэс Монгол ХХК-д санхүүгийн хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн тул төсөл арга хэмжээнүүд тодорхойгүй хугацаагаар хойшлогдоод байна.	0
“Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрыг түшиглэн “Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн парк байгуулах ажлын хүрээнд дэд бүтэц барих	Төслийн нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл болон байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг боловсруулсан /5 хувь/.	Үйлдвэрлэл, технологийн паркийн авто зам, дулаан, ус хангамж, төмөр зам, ариутгах татуургын сүлжээ барих ажлыг эхлүүлнэ /100 хувь/.	Үйлдвэр технологийн паркийн (ҮТП) авто зам, төмөр зам, ус хангамж, ариутгах татуургын системийн зураг төсөл, төсвийг гүйцэтгэж, Барилгын хөгжлийн төвөөр батлуулсан. Цахилгаан хангамжийн ТЭЗҮ-ийг 100 хувийн гүйцэтгэж, ЭЗХЯ-ны Шинжлэх ухаан технологийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Батлагдсан зураг төсөл хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний дагуу дэд бүтцийг барьж байгуулах ажлын гүйцэтгэгийг сонгох тендер шалгаруулалтын ажлыг эхлүүлээд байна.	50
4.2.11. Эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж, экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.				
Газрын тос дамжуулах хоолой барих төслийн техник, эдийн засгийн үндэслэл, инженер техникийн зураг төслийг боловсруулж батлан, барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг зохион байгуулах	Дамжуулах хоолой барих төслийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, трассын дагуух газрыг тусгай хэрэгцээнд авсан байна. Техник, эдийн засгийн үндэслэлийг хүлээн авсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	Дамжуулах хоолойн инженер техникийн зураг төслийг боловсруулах, батлуулах ажлыг зохион байгуулж, барилга угсралтын ажлыг эхлүүлсэн байна. Хэрэгжилт 40 хувьд хүрсэн байна.	Дорноговь аймагт 1334.66 га, Дорнод аймагт 1386.2 га газрыг дамжуулах хоолойн хэрэгцээнд зориулан “Улсын тусгай хэрэгцээ”-нд авахыг тус аймгийн ИТХ-аар дэмжсэн шийдвэр гарсан. Барилга угсралтын үеийн түр кемпүүдийн барилгын ажлыг эхлүүлээд БУА 35 хувийн, түр замын ажил 15 хувийн, Геодезийн цэг тэмдэгт суулгах ажил 100 хувийн, байр зүйн зураглалын судалгааны ажил 100 хувийн, мэдээлэл боловсруулах, тайлан бэлтгэх ажил 60 хувийн, геотехникийн судалгааны ажил 80 хувийн, дээжлэлт шинжилгээ 80 хувьтай байна. Канад улсын Ворлэй Инженеринг компани дамжуулах хоолойн Суурь Инженерчлэлийн Загвар (FEED) боловсруулах ажлын явц 25 хувьтай байна. БОАЖЯ-аас байгаль орчны ерөнхий үнэлгээний дүгнэлт хийсэн.	50

Газрын тос боловсруулах үйлдвэрийн барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөгөөний дагуу гүйцэтгэх ажлыг зохион байгуулж, дэмжлэг үзүүлэх	Лицензгүй болон үйлдвэрийн хэрэглээний бус байгууламж, үйлдвэрийн цахилгаан станцын барилга угсралтын ажлуудыг эхлүүлсэн байна. Мөн лицензтэй байгууламжийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Хэрэгжилт 10 хувьтай байна.	2020-2021 онд хийж эхэлсэн барилга угсралтын ажлуудыг дуусгаж, лицензтэй байгууламжийн барилга угсралтын ажлыг эхлүүлж, гүйцэтгэлийг 60 хувьд хүргэсэн байна.	Цар тахлын нөхцөл байдал, тендерт ирүүлсэн үнийн саналаас шалтгаалан /ЕРС-2/, /ЕРС-3/ багц ажлын шалгаруулалт удааширсан. Түргэвчилсэн тендер явуулж 2022.10.28-ны өдөр ерөнхий гүйцэтгэгчтэй гэрээг байгуулсан. /ЕРС-4/-ын лиценз эзэмшигчдийг шалгаруулсан, ерөнхий гүйцэтгэгчийг шалгаруулах ажил хийгдэж эхэлсэн	70
“Уул уурхай-металлурги-химийн үйлдвэрийн цогцолбор” үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих ажлыг эхлүүлэх	Урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийг боловсруулсан /1 хувь/	Нарийвчилсан техник, эдийн засгийн үндэслэл, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, инженерийн зураг төсөл боловсруулж, дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, гүйцэтгэлийг 7.5 хувьд хүргэсэн байна.	Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ-ийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ нь БНХАУ-ын “China ENFI Engineering” компанитай хамтран боловсруулсан бөгөөд УУХҮЯ-ны ЭБМЗ-өөр 2022 оны 6 дугаар сарын 23-ны өдөр хэлэлцүүлэн, дэмжигдсэн. Барилга байгууламжийн суурийн ажил 2022 оны 8 дугаар сараас хийгдэж эхэлсэн.	30
<b>Дундаж үнэлгээ</b>				<b>40</b>

Эх сурвалж:Аудитын баг

Тусгай зөвшөөрлийн шилжилт хөдөлгөөнийг Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт

№	2019 он		2020 он		2021 он		2022 он	
	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр
1	5675359	Экотайкүүн	2723344	Монгол-Анар трэйд	6049516	Эрдэнэс метан	5945038	Ти Эс Пи Би
2	2861224	Эсто	5298092	Гурван-Үндэс	5100128	Нью голден кроун	5935288	Эм Жи Эл Гео хүдэр
3	3738191	Жамп-Алт	6305733	Наран хөхийн оргтл	2869594	Альшаа хайрхан	5866316	Талын эрэлчин групп
4	5581613	Хишигт хөндий	5931312	Ката	2718392	Хүрэмтийн хяр	5651581	Их очир мандал ресурс проспектинг ХХК
5	5938643	Гөюу эко монголиа	5615097	Гүүд прожект	ЧЛ74101835	А.Балжинням		
6	5107377	Си Эм Би	2019086	Хурай	5373298	Амьюс		
7	2554518	Мондулаан трейд	5950467	Гэгээн лотос	5460816	ГААС		
8	5947138	Эрдэнийн гурван олз	5950465	Гэгээн лотос	6496539	Канаси ватер		
9	5328918	Баянчулуут газар	5990662	Ар Эс И	5948126	Чалко минералз		
10	5529123	Юниверсальлоггинг	5723876	Арвинцайдам				
11			6207626	Алтан рио ресурс				

Ашигт малтмал, газрын тосны газарт бүртгэгдсэн боловч Татварын Ерөнхий газарт бүртгээгүй, татвар төлөгдөөгүй ААНБ-ын жагсаалт

№	2019 он		2020 он		2022 он	
	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр
1	2870312	Шинэ-Эрдэс	2450259	Гэр хороолол барилгажилт	5068827	Рэдхилмонголиа
2	2027615	Монголгазар	5403766	Улаанцахар		
3	5435528	Эрдэнэс-Тавантолгой	6460771	Эрдэнэс Тавантолгой майнинг		
4			2863847	Анхай-Интернэшнл		

Хавсралт 4

Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгэгдсэн/30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт орсон тодорхойлолттой боловч Татварын Ерөнхий газарт бүртгээгүй, татвар төлөгдөөгүй ААНБ-ын жагсаалт

№	2019 он		2021 он		2022 он	
	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр
1	2886197	Монгол манганейз натурал ресурс	2698161	Капитал авто сервис	5824699	Өвөрголд
2	5980356	Хардэл бэйс	5071569	Ди Эйч Пи	5959578	Трешур гоулд
3			5116635	Түвшингарав	6041132	Тэргүүн сод орд
4			5645794	Эн Си Жи Ти		

Хавсралт 5

Улсын бүртгэлийн ерөнхий газарт тодорхойлолтгүй /30-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчийн өөрчлөлт орсон/ бүртгэгдсэн ААНБ-ын жагсаалт

№	2019 он		2020 он		2021 он		2022 он	
	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр
1	2006057	Эрдэнэмандал	2003821	Эрчимбаян өлгий	2010895	Найнги	2023202	Мандал алтай групп
2	2007126	Баялаг-Орд	2053179	Нарантахилт	2010933	Дун-Эрдэнэ	2024594	Гуравт
3	2103869	Мөнхням хайрхан	2109638	Олонгол трейд	2028239	Тулгаттрейд	2025833	Шохойцагаан булаг
4	2614294	Сигма-Инженеринг	2293323	Давст-Оргил	2074737	Гурвансайхан	2041278	Минжитбулган гол
5	5080444	Тэргүүнгарц	2557339	Монголиан жемстонес индастри	2305097	Талстнуур	2050374	Шарын гол
6	5081416	Жи Би Эм	2567741	М гурван-Өв трейд	2542579	Их-Урсгал	2100231	Хосхас
7	5082544	МИМС	2662507	Мандахбулаг	2621169	Эс Жи групп	2550245	Монголболгаргео
8	5095638	Болдфоарда	2670232	Микмайнинг	2630028	Скорпионсервис	2582457	Тэнүүнбайгаль
9	5106656	Нагааранз	2681471	Цирконмайнинг	2643227	Хүдэн	2585367	Давстрейд
10	5108195	Жи Ар Ти Би	2703807	Суурьхана	2656523	Түмэн-Анд	2598477	Сүмбэрхунтан
11	5108314	Ийст эжиа майнинг	2716682	Ти энд Ти юникс	2726378	Талын жигүүр	2640635	Барилга-Орд
12	5109345	Эхмөрөн	2765853	Гүнбилэг трейд	2763389	Тойванамдүү чинео	2641984	Цементшохой
13	5131871	Нарийн гол гоулд	2775093	Ов энд тулга	2793016	Төв азийн гантиг	2645556	Сантавиач
14	5195667	Такаражин	2881136	Цогш	2848317	Монголцамхаг	2708701	Баян-Айраг эксплорэйшн
15	5244552	Коол-Адвентурс	4369548	ОДНЭ	2851768	Сэрүүнсэлбэ	2732548	Мөнхийн хэлхээ



16	5278309	Хар-Алмандин	5003539	Нордвинд	3552004	Онолтмөнх	2772388	Танлон
17	5303265	БЭТТА	5036577	Жи Эй Кэй	5039932	Дарханфлюорит	2840995	Алтантөхөм
18	5311918	Алтан эрдэнэ газар	6280161	Мига эрин зуун	5051665	Кратон	3197549	Олз гоулд майнинг
19	5338085	Террамайнинг	5057035	Тэнгэрийн гэгээн тал	5072115	Шармонгол	5024021	Файвхиллс ресурс
20	5366941	Мальфлюорит	5061989	Хатанцацал	5079942	Билгүүн-Эрдэс	5036909	Бүрдэнговь групп
21	5441021	Эм Ай Би Эм	5072948	Эрдэнийн олз	5084555	Саусгоби сэндс	5059755	Баяжихманлай
22	5599695	Жуо юүэ жин энерги монголиа	5073189	Илтгоулд	5097215	Гоулд-Оптивелл	5083265	Ай Эн Ди
23	5609321	Матад энерги	5076021	ЖМЭ	5103576	Саруулсансар	5096871	Үлэмж-Алт
24	5650275	Талстдөл баяжмал	5076307	Ньюфлюорит	5130662	Эй Эл Жи Ти	5097428	БММЖ
25	5654769	Өсөх түмэн баясах	5087163	Дүншли	5163803	Жорчидай	5102545	Нарлагговь жем
26	5722616	Жамцдавс	5103797	Грийн энерги просперити	5167337	Интерсале	5110297	ЗТХ
27	5860032	Андын харгуй	5994349	Баруун гео	5198321	Флюоритстар	5121442	Эм Эл Ти престиж
28	5896746	Иххүрмэн	5108616	Есөнхаш эрдэнэ	5244501	Андсөүрвэй	5145414	Мөнхийн номхон далай
29	5968216	Терра виста	5109418	Стратажео	5267552	Налгархөндий	5155568	Эн И Си
30	6016677	Инэл гео	5138868	Монголзүрх сэтгэл	5292026	Талстгөлтгөнө	5214335	Ядам-Од
31	6087892	ГД трейд	5150884	Монгол ураниум ресурс	5309085	Вайлдстепп	5226775	Алтайхянган
32	6134335	Мон хуа энерги	5926629	ПЛ майнинг	5320569	Ихэргурван цохио	5229049	Ньюхаппи
33	6152392	ЭЖ эрдэнэ майнинг	5884098	Болдгянтболд	5329434	Ургахморин элс	5308488	Жэй Си Си Ар
34	6172229	Төгрөг нуур девелопмент	5216656	Эдинбург	5376467	Билэгтхайрхан уул	5315425	Би Си Эм Эм
35			5240964	Хангайлэнд	5443431	ЖЕЛГОР	5327229	Дальняяземля
36			5256267	Дорныншим	5564913	Гүн-Орд	5340195	Харзанар
37			5266386	Асгат-Эрдэнэ	5623499	И Эс энд Си Эс	5383854	Мөнгөнхас шонхор
38			5276764	Сонголонхайрхан	5744563	Түвшинтөр трейд	5412153	Меланж
39			5288703	Си Эм Кэй Ай	5753597	Чаминхарш	5528089	Кингдаймонд
40			5310679	Алтан очирт титэм	5925614	Цог-Урин	5584345	Трой-Унц
41			5317312	Алтан эрдэнийн орд	5991625	Кюбэра	5596106	Дорнодкоппер
42			5353246	Баян өндөр ресурс	5994152	Хан рояал	5673569	Космокоал
43			5493706	Алекс металс	6097936	Стар флюорит	5694604	Тавтаанаймайнинг
44			5497272	Мандах дорнын жонш	6112455	Тарагт гөлтгөнө	5807697	Восточный дорог
45			5559731	Батзуурмаг	6165451	ХӨД	5824699	Өвөргөлд
46			5722438	Металл эрэл хайгуул	6171788	Империал гоулд майнинг	5876826	Адексмайн
47							5921244	Майнперфект сольюшн
48							5931592	Хас-Агро
49							5976367	Билүүт эрдэс
50							6052118	Булган од майнинг
51							6134254	Оргил сэр
52							6140416	Майпло майнинг девелопмент

## Татварын ерөнхий газарт татвар төлж бүртгэгдсэн боловч Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлээгүй аж ахуйн нэгж байгууллагын жагсаалт

№	2019 он		2020 он		2021 он		2022 он	
	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр	Регистрийн дугаар	ААН-ийн нэр
1	5824699	Өвөрголд	5824699	Өвөрголд	5287359	Хантэнгэрийн дуудлага	5155312	Шинэ баялаг
2	6014208	Цогзол орших	5109264	Зэст-Алтай	4270177	Зөв газар элемент	6010822	Белуха
3	6165524	ХТД	2701391	Эс и и ди	5189128	Эс Кью Эс	2789213	Хризопраза
4	6267408	Чингис ворлд майнинг	5504767	Эм Ди Эф И	5189128	Эс Кью Эс	6503217	Кратос майнинг корпораци
5	5120365	Сумэру	5943329	Бугант дорф	5908027	Чингисийн алтан зоос	6485839	Мидас ресурсез
6	3753603	Сэлэнгэ байгалын нөөц	6438776	Монголиан токен майнинг инвестмент групп корпорейшн	2618532	Дамбат	5882346	Өгөөмөр говийн нуур
7	5320607	Шувуун хар уул	5105439	Талстдөл	5486238	Сансар сүлжээ	5761689	Хөхгазрын шим
8	5991439	Баян дэлгэрийн өвөр	5945674	Ар Ай Жи Эс	5745721	Мэжикмэнс	5306892	Их монгол коммерс
9	5209358	Алтан динар	5935113	Хүлэгтмайнинг	5508762	Профиргеологи	6717128	Рагнарок инвестмент
10	5250684	Апро	5946239	Монгол металл консалтинг	2848066	Вестернресурс	5347548	Глабол балыш
11	5297117	Эм Си Эй Ди	6085571	Найртын дэнж	6358187	Силкрөүд майнинг трэйд	6077455	Руби стоун
12	5946239	Монгол металл консалтинг	3865258	Голденгрэвел	5029953	Алтай хангай бүрд	6161669	Геосоорс
13	5824699	Өвөрголд	5035503	Би Эс Ай	5407761	Бритишмайнинг	5874157	Конгломерат
14	6003761	Вест смарт майнинг	5929474	Платин-Энержи	6161669	Геосоорс	5292638	Рэдвулкан
15	5982588	Минерал эксплорэйшн энд девелопмент	5861519	Цэнгүүншилтгээн	6019935	Нарангоулд	2589184	Ориент
16	2012677	Аргатай	6112633	Тайхаржин майнинг	5209447	Гермес гахиур	2621169	Эс Жи групп
17	2603365	Боржигт	5950562	СННС	5651581	Их очир мандал ресурс проспектинг	2848376	Тээлийн шонхор
18	5930537	Хүлэг голд	5651581	Их очир мандал ресурс проспектинг	6208673	Хүнхэрийн хөндий	5328918	Баянчулуут газар
19	5116635	Түвшингарав	5350859	Цогц эрин транс	5411726	Эжилешия	2546574	Түшээговь
20	2670801	Заамарын их алт	5021693	Тинаха	6679439	Ургах шигтгээ	6300693	Голден гоби констракшн материалз
21	5134617	Сүмбэр-Орд	5864801	Кенросс майнинг	2668548	Гоулд ланд	3557588	Дун-Уянга
22	5197325	Шанжин орд	5965861	Нэшнл коин майнинг	2775476	Одод шарын гол	5199166	Өнгөт маргад
23	5279216	Тахамт	5292638	Рэдвулкан	4270177	Зөв газар элемент	5481694	Монголиан метал майнинг групп

24	5154715	Эм Эн Эл Жи	5292638	Рэдулкан	5095719	Говьмастер	6002129	Хос-Уул
25	2096277	Дельфин	5990637	Эм Ди Жи Эм	5199166	Өнгөт маргад	6503217	Кратос майнинг корпораци
26	5958075	Эй энд капитал	6014208	Цог зол орших	5990572	Родео Аруга	5945674	Ар Ай Жи Эс
27	5688256	Ухаа хурд	5930537	Хүлэгголд	5754992	Вайлдстепп	5072085	Бидний зорилго
28	5088321	Дабльштутце	6169325	БХДБ	6496539	Канаси ватер	5287359	Хан тэнгэрийн дуудлага
29	5072085	Бидний зорилго	5222443	Бужгар-Орд	5346339	Ай Ар И Ай Эн Ти Эл	6496148	Өгөөж их орд
30	5250684	Апро	5250684	АПРО	5797464	Олз газар	5359058	Миранд
31	5359058	Миранд	5346339	Ай Ар И Эн Ти Эл	5120365	Сумэру	6077455	Мээрэн мета металс
32	2621169	Эс Жи Групп	5535271	Дэлгэрэх газар	5857643	Цахиурт ресурс	5155312	Шинэ баялаг
33	5948126	Чалко минералз	5153077	Мөнхсаяан	6261485	Баян фү жин	5084024	Ловонко
34	5948126	Чалко минералз	6041132	Тэргүүн сод орд	5189128	Эс Кью Эс	3644693	Говь номгон тэнгэр
35	5798019	Эко энвайронментал консалтинг	2160757	Дүүлэх шонхор	5197325	Шанжин-Орд	6737501	Ларимар
36	5980232	Билэгт арвижих	5456924	Ар Эн Эм	5861519	Цэнгүүн шилтгээн	6650384	Гоулд циркл
37	4183525	Тэрмэн жонш	5230977	Тогоо толгой	5929474	Платин энерги	6667791	Плетора
38	2028565	Төвшин	5211859	Эрдэнийн босго	6207235	Эрч гоулд	6485839	Мидас ресурсез
39	5241359	Борж-Овоот	5203643	Пакимор			5535271	Дэлгэрэх газар
40	3319113	Баян цомог	5909805	Хүдэрт майнинг ресурс			6528732	Баян хөх толгой ташгай
41	5236517	Гокбулган уул	6141536	Эрдэнэсийн эрэг			5942136	Ар Эм Си Трэйд
42	5645794	Эн Си Жи Ти	2267438	Дөрвөнхүмүүн ББН			6209815	Эм Өү Юү майнинг
43	5990572	Би Эм Ди Эм	2096277	Дельфин			6395864	Умард оргил
44	6165478	ЦРД	6130062	Төгс майнинг			6009565	Батбадмаараг
45	5133408	Талст-Орчлон	5250684	Апро			6621376	Бөхөн минералс
46			5262763	Тод Цахир			2009765	Хэрлэн-Импекс
47			6085571	Найртын дэнж			6706878	Талын номт ХХК
48							6750966	Зүчи ресурсэс ХХК
49							5347548	Глобалбалыш ХХК
50							6755291	Интерконтиненталь ХХК